

# УВС АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

*/эхний 3 дугаар улирал/*

2019.10.03

Улаангом

## **Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:**

*1.1. Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам болон дээд шатны байгууллагаас гаргасан хөтөлбөр, төлөвлөгөө, үүрэг, ажлын чиглэл болон холбогдох эрх зүйн баримт бичигт тусгагдсан ажил, арга хэмжээний хэрэгжилтийг ханагх чиглэлээр:*

Тус цагдаагийн газар Цагдаагийн албаны тухай хууль, Галт зэвсгийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, УИХ-ын 2016 оны 19, 121, 233, 2010 оны 48, 2018 оны 37 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 261, 2009 оны 303, 2010 оны 289, 2012 оны 146, 2015 оны 346, 2017 оны 98, 142, 148, 270, 143, 2018 оны 163 дугаар тогтоол, 2019 оны 57, 59 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 88 дугаар зарлигийн 1, 3 заалт, 2007 оны 97 дугаар “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж байх тухай зарлиг, Улсын Их Хурлын Байнгын хорооны 2013 оны 02, 2014 оны 08, 2015 оны 28, 2016 оны 10, 2018 оны 02, 24 дүгээр тогтоол, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2017 оны 19/15, 2018 оны 06/05, 12/09 дугаар зөвлөмж, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 410, 2016 оны 29, 2017 оны 142, 195, 196, 249, 2018 оны 11, 50, 258 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 68 дугаар захирамж, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 1 дүгээр хуралдааны тэмдэглэл, 2017 оны 44, 48, 2019 оны 5 дугаар хуралдааны тэмдэглэл болон ЦЕГ-ын даргын тушаал, албан даалгавар үүрэг, ЦЕГ-ын Тэргүүн дэд болон дэд дарга ба төвийн албадаас ирүүлсэн ажлын чиглэл, тодорхой төрлийн ажлын төлөвлөгөө, албан даалгавруудыг хэрэгжүүлэх ажлыг тасгийн дарга нарт хариуцуулан зохион байгуулж байгаа ба дээр дурьдсан эрх зүйн акт, баримт бичгүүдийн биелэлтийг улирал, хагас, бүтэн жилээр тооцуулахаар хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Энэ оны 1, 2 дугаар улиралд Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/42 дугаар тушаалаар баталсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2019 онд хяналтанд авч, хэрэгжилтийг хангах, хяналт-шижилгээ, үнэлгээ хийх, үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалт”-ын дагуу бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг гаргаж холбогдох алба, нэгжид хугацаанд нь хүргүүлж ажилласан.

Гуравдугаар улирал болон жилийн эцсийн баримт бичгүүдийн биелэлтийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/162 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2019 онд хяналтанд авч, хэрэгжилтийг хангах, хяналт-шижилгээ, үнэлгээ хийх, үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалт”-ын дагуу хугацаанд тайлагнан ажиллах ба биелэлт үр дүнг тооцох баримт бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор баримт бичиг бүрийг эзэнжүүлж, хэрэгжилтийн явц, үр дүнтэй цагдаагийн газрын дарга сар бүр биечлэн танилцаж байна.

*1.2. Байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудал, тушаал, шийдвэрийн талаар*

Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар 2019 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг жилээр гаргаж, цагдаагийн газрын даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу даргын зөвлөлийн хурлыг зохион байгуулан ажиллаж байна.

Цагдаагийн газрын даргын ээлжит хуралдааныг даргын тушаалаар тогтсон өдөр, цагт явуулж, ээлжит бус хуралдааныг зайлшгүй шаардлагатай гэж үзвэл даргын товлон зарласнаар хуралдуулж байна.

Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байна. Үүнд:

1. Цагдаагийн төв байгууллагын дарга болон дээд шатны байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгавар, бусад шийдвэрүүд, түүний мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай асуудал;
2. Хүний нөөцийн асуудал;
3. Цагдаагийн газрын санхүү, төсвийн асуудал;
4. Цагдаагийн газрын үндсэн үүрэг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудал;
5. Цагдаагийн газарт мөрдөгдөх журам, заавар, тушаалын төсөл;
6. Цагдаагийн газрын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой тулгамдаж буй асуудал зэргийг хэлэлцэж байна.

Тус цагдаагийн газрын даргын зөвлөл энэ оны эхний 3 дугаар улирлын байдлаар 21 удаа хуралдаж хурлыг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Даргын зөвлөл байгуулах, асуудал хэлэлцэх /код 104/ журам”-ын дагуу явуулж, нийт 112 тушаал, шийдвэр гаргасан байна.

### 1.3. Хүний нөөцийн талаар:

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/135 дүгээр тушаалын 19 дүгээр хавсралтаар тус цагдаагийн газрын бүтэц, орон тоог 161 орон тоотойгоор баталсан ба удирдах албан тушаалтан 1, гүйцэтгэх албан тушаалтан 157, хөдөлмөрийн гэрээгээр /ТҮ/ ажиллагсад 3 байгаагаас 2018 онд Өмнөговь сум дахь цагдаагийн хэсгийн цагдаагийн 1 орон тоог ЦЕГ-ын Сүлд чуулгад шилжүүлж, нийт 160 орон тоотой болсон.

Тус цагдаагийн газарт одоо ажиллаж байгаа алба хаагчдын 72 буюу 46.7 хувь нь төсөвт офицер, 77 буюу 50 хувь нь төсөвт ахлагч, 4 буюу 2.5 хувь нь гэрээт ахлагч, 3 буюу 1.9 хувь нь төсөвт энгийн ажилчид байна.

Нийт бүрэлдэхүүний 138 буюу 91.4 хувь нь эрэгтэй, 13 буюу 8.6 хувь нь эмэгтэй алба хаагч байгаа бөгөөд насны ангилалаар нь авч үзвэл 18-25 настай 47 буюу 31.1 хувь, 26-35 настай 72 буюу 47.6 хувь, 36-45 настай 28 буюу 18.5 хувь, 45-аас дээш настай 4 буюу 2.6 хувийг эзэлж байна.

Алба хаагчдыг боловсролынх нь түвшингээр нь ангилж үзвэл 119 буюу 78.8 хувь нь дээд, 4 буюу 2.6 хувь нь тусгай дунд, 28 буюу 18.5 хувь нь бүрэн дунд боловсролтой байна.

Энэ оны 03, 06 дугаар сард ЦЕГ-аас зарласан ажлын байрны сул орон тооны сонгон шалгаруулалтанд 55 иргэний хүсэлтийг хүлээн авч судлаж, эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүй, монгол хэл бичгийн шалгалтыг авч, тэнцсэн 6 иргэнийг Цагдаагийн ерөнхий газраас зохион байгуулсан шалгалтанд хамруулахаар холбогдох материалыг бүрдүүлэн ЦЕГ-ын Хүний нөөцийн хэлтэст хүргүүлсэн ба Дотоод Хэргийн Их сургуулийн ахлагчийн сургуульд суралцаж төгссөн 3 иргэнийг ажлын байраар хангасан.

Ажлын байр /албан тушаал/-ны сул орон тооны сонгон шалгаруулалтын зарыг тус аймагт үйл ажиллагаа явуулдаг “УВС”, “МВС”, “УВС нам бус телевиз” болон цагдаагийн газрын [www.uvs.police.gov.mn](http://www.uvs.police.gov.mn) цахим хуудас, Увс аймаг дахь цагдаагийн газар нэртэй

facebook хуудас, цагдаагийн газрын мэдээллийн самбар зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлан ажилласан.

Мөн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны Б/181 дүгээр тушаалаар Хууль сахиулахын Их сургуулийн 2.5+(2)+1.5 жилийн сургалтанд суралцаж, Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын салбар зөвлөлийн 2019 оны 02 дугаар тогтоолоор “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д бүртгэгдсэн 2 иргэнийг тус цагдаагийн газрын албан тушаал /ажлын байр/-ын сул орон тоонд томилуулж, хүний нөөцийн нөхөн бүрдүүлэлтийг тасралтгүй зохион байгуулан ажиллаж байна.

Түүнчлэн 2019 оны 09 дүгээр сард ЦЕГ болон төрийн албаны салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулагдаж байгаа албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтанд 56 иргэний өргөдөл, хүсэлтийг хүлээн авч судалж, шаардлага, шалгуур хангаж байгаа 12 иргэнийг ЦЕГ-аас зохион байгуулах шалгалтанд оролцуулахаар материалыг бүрдүүлээд байна.

Мөн энэ оны эхний 3 дугаар улирлын байдлаар албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн 1 алба хаагчийг тасгийн даргаар, 3 алба хаагчийг хэсгийн даргаар, 2 алба хаагчийг ахлах албан тушаалд дэвшүүлэх, 1 алба хаагчийг офицерын бүрэлдэхүүнд оруулах, 15 алба хаагчийг шилжүүлэн томилуулах, 6 алба хаагчийг шинээр томилуулах саналыг ЦЕГ-ын Хүний нөөцийн хэлтэст хүргүүлэн шийдвэрлүүлсэн.

Одоо тус цагдаагийн газарт эрүүгийн ахлах мөрдөгч 1, хэсгийн төлөөлөгч 3, хэсгийн цагдаа 2, бичиг хэргийн эрхлэгч, архивч 1, бичээч 1, нярав 1 нийт 9 ажлын байр сул байна.

Эдгээр сул орон тоог нөхөх зорилгоор шалгуур шаардлага хангасан алба хаагчийг судлаж, хэсгийн төлөөлөгч болон бичиг хэргийн эрхлэгч архивчийн албан тушаалд томилуулахаар 2 алба хаагчийн материалыг Хүний нөөцийн хэлтэст хүргүүлсэн.

#### *1.4. Алба хаагчдын дунд зохион байгуулсан албаны сургалт, түүний үр дүнгийн талаар:*

Тус цагдаагийн газраас алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, албанаас зохион байгуулагдаж байгаа сургалтын чанар үр дүнг сайжруулах, алба хаагчдын ажил мэргэжлийн онцлог, ажилласан жил, ур чадварт зохицсон шинэлэг байдлаар зохион байгуулах зорилгоор “Албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө”-г тус цагдаагийн газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн А/02 дугаар тушаалаар баталж, албаны сургалтыг сар бүрийн 1, 3 дугаар долоо хоногийн “Лхагва” гарагт 16.00 цагаас зохион байгуулахаар “Дотоод журам”-д тусгасан.

Мөн цагдаагийн газрын төрөл мэргэжлийн тасаг, хэсгүүд дотооддоо зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг гарган газрын даргаар батлуулж сар бүрийн 2 дахь долоо хоногийн “Баасан” гарагт сургалт зохион байгуулж байна.

Тус цагдаагийн газраас энэ оны эхний 3 дугаар улиралд дараах сургалтуудыг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу алба хаагчдын дунд зохион байгуулсан. Үүнд:

Тус цагдаагийн газраас энэ оны 3 дугаар улиралд мэдвэл зохих хууль тогтоомжийн 19 удаагийн сургалтад 2479, алба хаагчийг хөгжүүлэх 17 удаагийн сургалтад 2209, дадлагажуулах 3 удаагийн сургалтад 401, бие, бялдрын бэлтгэлжилтийн 6 удаагийн сургалтад 655, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан 9 удаагийн сургалтад 1302 алба хаагч, нийт 54 удаагийн сургалтад 7046 /давхардсан тоогоор/ алба хаагч хамрагдсан байна.

Цагдаагийн Ерөнхий Газар, Авилгатай тэмцэх газраас зохион байгуулсан цахим сургалтад цагдаагийн газрын даргын зөвлөлийн гишүүд болон байгууллагын ХОМ хариуцсан эрх бүхий албан тушаалтан хамрагдсан.

Цагдаа дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвөөс зохион байгуулсан” Жендер ба хүний эрх” цахим сургалтанд алба хаагчид хамрагдсан.

### ***Мэдвэл зохих хууль, тогтоомжийн сургалтын талаар:***

Шинээр батлагдсан хууль, тогтоомжууд, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын өөрчлөлт, шинэчлэл, хяналт, шинжилгээ, үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт гэх мэт сургалтууд зохион байгуулсан.

Мэдвэл зохих хууль тогтоомжийн 19 удаагийн сургалтыг 20 цагийн хугацаатай зохион байгуулж 2479 алба хаагч/давхардсан тоогоор/ хамрагдсан байна.

Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Галт зэвсгийн тухай хууль болон түүнийг хэрэглэх нь, Архив, албан хэрэг хөтөлөлтийн стандартын талаар болон Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 2018 оны А/299, 2019 оны А/44, А/26, А/67 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 9 дүгээр бүлгийн журмууд/ код-921/-аар, /код-209 “Осол гэмтлийн үед анхны тусламж үзүүлэх”, код-214 “Бичиг баримт үзэж шалгах”, /код-222 “Байгууллага, иргэний орон байранд нэвтрэн орох”, /код-223 “Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүнийг баривчлах, төрийн байгууллагад хүргэх”, /код-232 “Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон гадаадын иргэнтэй харилцах”, /код-234 “Биеийн хүч тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх”, /код-629 “Албадан эрүүлжүүлэх”, Галт зэвсэг хэрэглэсэн тухай илтгэх журам, Цагдаагийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйл “Цагдаагийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага”, мөн хуулийн 29 дүгээр зүйл “Үзлэг хийх” зэргээ сургалтыг зохион байгуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар шинэчлэн батлагдсан “Цэргийн жагсаалын шинэчилсэн дүрэм” болох 7 бүлэг 15 заалтаар сургалтыг зохион байгуулсан.

Төрийн албаны салбар зөвлөл болон Аймгийн төрийн захиргаа удирдлагын хэлтсээс тус аймгийн төрийн байгууллагуудын дунд зохион байгуулсан сургалтанд “Төрийн албаны тухай хуулийн шинэчлэл, төрийн албаны зарчим” сэдэвт сургалтад Цагдаагийн газрын дэд дарга, цагдаагийн хошууч Ц.Жамбалдорж, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Ж.Дөлбадрах, хүний нөөцийн мэргэжилтэн, цагдаагийн ахмад Б.Энхсаруул нар алба хаагч хамрагдсан.

Хууль зүйн сайдын 2013 оны А/248 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний харъяа агентлаг, байгууллагын эрсдлийн үнэлгээ хийх аргачлал”, “Цагдаагийн байгууллагын эрсдлийн удирдлага /код 137/ журам”-аар алба хаагч нарт сургалтыг зохион байгуулсан.

### ***Алба хаагчийг хөгжүүлэх сургалтын талаар:***

Тус цагдаагийн газраас 3 дугаар улиралд Алба хаагчийг хөгжүүлэх сургалтыг 17 удаа 17 цагийн хугацаатайгаар зохион байгуулж 2209 алба хаагч/ давхардсан тоогоор/ хамрагдсан.

Аймгийн Онцгой байдлын газрын байцаагч, хошууч Д.Пүрэвжавтай хамтран алба хаагчдад “Гамшиг, ослын үед цагдаагийн алба хаагчаас хийж хэрэгжүүлэх ажил, анхаарах асуудал”, Аймгийн архивын тасгийн дарга Д.Тэсхүү болон Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Э.Наранмандах нартай хамтран “Ашиг, сонирхлын зөрчлөөс

ангид байх, урьдчилан сэргийлэх, хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлэх нь” сэдэвт сургалтыг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Увс аймаг дахь зөвлөгч Энхтуяа “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцах нь”, Багш хөгжлийн институтын ахлах багш Д.Тунараа “Сэтгэл зүй ба гэр бүл”, Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлийн гишүүн Д.Гэжээ “Төрийн алба хаагчийн ёс зүй”, “Удирдлагын манлайлал, ёс зүй”, Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Н.Мөнхзул “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцах нь”, ЭМНЕСТИ интернэшнл төрийн бус байгууллагатай хамтран “Эрүүдэн шүүх гэж юу вэ?”, “Хүний эрхийг хамгаалагчийн эрх зүйн орчин”, Хилийн 0245-р ангитай хамтран Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар шинэчлэн батлагдсан “Цэргийн жагсаалын шинэчилсэн дүрэм” болох 7 бүлэг 15 заалтаар тус тус сургалтыг зохион байгуулсан. Мөн ЦЕГ-ын дэд даргаас ирүүлсэн ажлын чиглэлийн хүрээнд алба хаагчдад “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”, “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм” –үүдээр албаны сургалтыг зохион байгууллаа.

### ***Дадлагажуулах сургалтын талаар:***

Батлагдсан хөтөлбөр төлөвлөгөөний дадлагажуулах сургалтыг 3 удаа 5 цагийн хугацаатайгаар зохион байгуулж 401 алба хаагч хамрагдсан.

Цагдаагийн газрын нийт алба хаагчдын дунд “Цагдаагийн алба хаагчийн аюулгүй байдал, түүнд анхаарах асуудал”, “Цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүйн зөрчлийг бууруулах нь” сэвдээр хэлэлцүүлэгийг нийт алба хаагчдын дунд зохион байгуулж, хэлэлцүүлэгээс гарсан санал, уриалыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Мөн алба хаагч нарт “Гэр бүлийн үнэ цэнэ” сэдэвт сургалтыг сэтгэл зүй, цагдаагийн дэслэгч Ц.Оюундарь зохион байгуулсан.

### ***Бие бялдрын бэлтгэлжилтийг хангах сургалтын талаар:***

Алба хаагчдын бие бялдрын бэлтгэлжилтийг хангах сургалтыг 20 удаа 40 цагийн хугацаатайгаар зохион байгуулж 2600 алба хаагч хамрагдсан. Бие бялдрын бэлтгэлжилтийг хангах сургалтыг Аймгийн Биеийн тамир спортын газартай хамтарч долоо хоног бүрийн Пүрэв гарагт 18.00-20.00 цагийн хооронд зохион байгуулж хэвшсэн.

Мөн алба хаагч нарын дунд “Эрүүл-агаар-Идэвхитэй хөдөлгөөн” нэг сарын аяныг өрнүүлж, долоо хоног бүрийн Даваа, Лхагва, Баасан гарагуудад өглөө 06.00 цагаас 3 километрийн явган гүйлтийг зохион байгуулж, гүйлтийн дараа дасгал хөдөлгөөнийг өрнүүлж, алба хаагчдад хүчилтөрөгчийн коктайлаар үйлчилж ажилласан.

Тус цагдаагийн газраа өдөр бүр 10 цаг 40 миунтаас I, II, III давхрын алба хаагчид ажлын байрандаа хийх дасгал хөдөлгөөнийг хийж хэвшээд байна. Мөн алба хаагчдын дунд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдрын бэлтгэлжилтийг хангах чиглэлээр дугуйн аялалыг зохион байгуулсан.

Мөн алба хаагчдын бие, бялдыг хөгжүүлэх, эрүүл аж төрөх, дадал, хэвшил бий болгох зорилгоор биеийн тамир, спортын уралдаан тэмцээний удирдамжийг цагдаагийн газрын даргаар батлуулан хуваарийн дагуу зохион байгуулсан.

#### ***1.5. Алба хаагчдын нийгмийн асуудал, үүрэг гүйцэтгэх нөхцөл боломжийг хангах чиглэлээр хэрэгжүүлэн ажил арга хэмжээ***

Алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, үүрэг гүйцэтгэх боломжийг хангахад анхаарч сумдын алба хаагчдын гэр бүлийг ажлын байраар хангах, алба хаагчдыг орон сууцны хөнгөлттэй зээлд хамруулах ажил арга

хэмжээг зохион байгуулах ажлыг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус аймгийн 19 суманд үүрэг гүйцэтгэж байгаа 51 алба хаагчдаас 37 буюу 72.5 хувь нь ганцаараа амьдарч байгаа судалгаатай шинээр томилогдсон газрын дарга танилцаж, хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын ажил, амьдралтай танилцах ажлыг тус цагдаагийн газрын дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн даргаар ахлуулж Тэс, Өмнөговь, Өндөрхангай сум дахь цагдаагийн хэсэг болон Түргэн, Сагил, Давст, Ховд, Өлгий, Наранбулаг, Зүүнхангай, Цагаанхайрхан, Зүүнговь, Хяргас, Малчин, Тариалан сумын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын ажил, амьдралтай нь газар дээр нь энэ оны 08 дугаар асрын 26-ний өдрөөс 09 дүгээр сарын 03-ний өдрийн хооронд очиж танилцаж, алба хаагчдын санал хүсэлтийг хүлээн авч цагдаагийн газрын даргад танилцуулсан.

Алба хаагчдаас гаргасан хүсэлтийн дагуу Улаанбаатар хотод гэр бүл нь амьдарч байгаа Тэс сум дахь цагдаагийн хэсгийн замын цагдаагийн зохицуулагч, цагдаагийн дэслэгч Ц.Отгонбаяр, Малчин сумын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Залуу-Од нарыг Улаанбаатар хот руу, аймгийн төвд гэр бүл нь амьдарч байгаа Сагил сумын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч Ц.Эрдэнэболд, Цагаанхайрхан сумын хэсгийн төлөөлөгч Ж.Мөнхбаяр нарыг аймгийн төвд шилжүүлэх саналыг ЦЕГ-ын Хүний нөөцийн хэлтэст хүргэж шийдвэрлүүлсэн.

Дээрх сумдын алба хаагчдын ажил, амьдралтай танилцахаас гадна сумдын удирдлагуудтай уулзаж, тэргүүн эгнээнд алба хаагчдын гэр бүлийг ажлын байраар хангах, автомашин, мотоцикль болон бусад шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахыг уламжилж, гурвалсан гэрээний биелэлтийг хангаж ажиллах талаар үр дүнд хүрэхүйц уулзалтыг хийсэн.

Энэ оны эхний 3 дугаар улирлын байдлаар 4 алба хаагчийн гэр бүлийг ажлын байраар хангаж, 2 алба хаагчийг орон сууцны хөнгөлттэй зээлд хамруулсан.

Мөн алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн дараах ажил арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Цагдаагийн албаны тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.2-д заасан болзол, шалгуурыг хангасан 8 алба хаагчийн материалыг бүрдүүлж, 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгуулсан.

2. Орон сууцны хөнгөлттэй зээлд хамрагдах хүсэлтэй 2 алба хаагчийг хөнгөлттэй зээлд хамруулсан.

3. Шуурхай удирдлагын тасгийн даргын өрөөг засварлаж ашиглалтанд оруулсан.

4. Цагдаагийн газрын дундын сангаас шинээр хүүхэдтэй болсон 4 алба хаагчид 200000 төгрөг, ар гэрийн гачигдал гарсан 4 алба хаагчид 1200000 төгрөг, эмчилгээ сувилгаанд явсан 3 алба хаагчид 600000 төгрөг, нийгмийн бусад асуудалд 1200000 төгрөг, нийт 3200000 төгрөгийн дэмжлэг туслалцаа үзүүлсэн.

5. Шинээр томилогдсон болон шилжиж ирсэн урьд онд хамрагдаагүй нийт 48 алба хаагчийг элэгний В, С вирусын баталгаажуулах шинжилгээнд хамруулсан ба шинжилгээгээр вирусгүй гарсан 43 алба хаагч, ажилтан нарыг “Бат-үржихүй” Өрхийн эмнэлэгтэй хамтран элэгний В вирусын дархлаажуулалтын 3 тунт вакцинд бүрэн хамруулсан.

6. Цагдаагийн газрын 156 алба хаагч, ажилтанг гэнэтийн ослын даатгалд хамруулсан.

7. Аймгийн Эдийн засаг, нийгмийг 2019 онд хөржүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөгөө"-нд Өндөрхангай сумын цагдаагийн кобаны барилгад засвар хийх 20,0 сая төгрөг, сумдад олон нийтийн цагдаагийн ажилтан ажиллуулахад шаардагдах 20.5 сая төгрөг тус тус батлуулсан.

8. Цагаанхайрхан сумын цагдаагийн бичил байр /кобан/-ыг нэгдсэн халаалтанд холбосон.

9. Ховд сумын цагдаагийн бичил байр /кобан/-нд их засвар хийсэн зэрэг ажил, арга хэмжээг хэрэгжүүлсэн.

*1.6. Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргаар уламжлан шийдвэрлүүлсэн ажил, арга хэмжээний талаар:*

Тус аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад энэ оны эхний 3 дугаар улиралд дараах хөрөнгийн шинжтэй асуудлуудыг хүргүүлэн шийдвэрлүүлсэн. Үүнд:

1. Өндөрхангай сум дахь цагдаагийн хэсгийн бичил байр /кобан/-ыг засварлахад зарцуулагдах 20 сая төгрөгийг шийдвэрлэх саналыг хүргүүлж энэ оны орон нутгийн төсөвт суулгуулж, засварыг эхлүүлсэн.

2. Мөн сум дахь цагдаагийн хэсгийн байрыг өргөтгөх зорилгоор тус сумын ахуйн үйлчилгээний 2 давхар байрыг блансаас блансад шилжүүлэх авах хүсэлтийг Засаг даргад уламжилж шийдвэрлүүлсэн.

3. Улаангом сумын 3 дугаар багийг телекамержуулахад зарцуулагдах төсөв, хөрөнгийн судалгаа, тооцоог гаргаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүсэн ба орон нутгийн төсөвт дээрх ажилд зарцуулагдах 50 сая төгрөгийг суулгуулж, энэ оны 9 дүгээр сард “Соноор мэлмий” ХХК-аар 15 цэгт 32 телекамер суурьлуулах ажлыг бүрэн гүйцэтгэсэн.

4. Зүүнговь сумын Засаг даргад хүсэлт уламжилж 2500000 төгрөгийг үнэ бүхий согтуурал хэмжих багаж худалдан авсан

5. Тариалан, Сагил, Бөхмөрөн сумын Засаг даргад хүсэлт хүргүүлж мотоцикль худалдан авахуулсан.

6. Улаангом сумын Засаг дарга болон ИТХ-д хүсэлт хүргүүлж хэсгийн байцагч нарыг принтер, сүүлийн үеийн гэрэл зургын аппарат, скайнераар хангасан.

7. Аймгийн ИТХ болон засаг даргад цагдаагийн газрын хойд жигүүрийн барилгад засвар хийхэд шаардагдах мөнгөн хөрөнгийг шийдвэрлүүлэх талаар уламжилсан ба аймгийн удирдлагын зүгээс Азийн хөгжлийн банктай зөвшилцөж дээрх барилгад засвар хийхээр шийдвэрлэсэн.

*1.7. Цагдаагийн байгууллагын чиг үүрэгтэй холбоотой бусад төрийн болон төрийн бус байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, хугацаа, үр дүн*

Тус цагдаагийн газрын чиг үүрэгтэй холбоотой бусад төрийн болон төрийн бус байгууллагаас энэ оны эхний 3 дугаар улирлын байдлаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр одоогоор байхгүй болно.

*1.8. Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ*

Тус цагдаагийн газраас авилгын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гарын авлага, санамж, зөвлөмж болон алба хаагчидтай холбоотой авлига, хээл хахууль, хүнд суртлын талаар мэдээллэх утасны дугаар бүхий хэвэлмэл хуудсыг тарааж ажилласан.

Тус аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын дунд “Хууль эрх зүйн” сэдэвт олимпиадыг аймгийн ГХУСАЗСЗ, Боловсрол соёлын газартай хамтран

зохион байгуулсан ба уг олимпиадын асуултанд авилгын эсрэг хууль тогтоомжийн 3 асуулт оруулж, багш, сурагчдад авилгын эсрэг хууль тогтоомжоор 1 удаагийн сургалтыг тус цагдаагийн газрын ЭБАТ зохион байгуулсан ба сургалтанд 21 багш, 450 сурагч хамрагдсан.

Түүнчлэн Авлигатай тэмцэх газраас иргэдэд зориулсан “Авлига, хээл хахууль хүнд сурталын эсрэг вакцин”, “Эрүүл авлигагүй, хээл хахуульгүй нийгмийн төлөө хамтдаа” “Шударга нийгмийн төлөө хамтдаа”, “Авлига- Боловсролын эсрэг гэмт хэрэг”, “Авлига-Хүний эрхийн эсрэг гэмт хэрэг”, Авлига-Хөгжил дэвшлийн эсрэг гэмт хэрэг”, Адлига- Байгаль орчны эсрэг гэмт хэрэг” зэрэг зурагт хуудас болон мэдүүлэг гаргагч нарт зориулсан 3 төрлийн зурагт хуудас, Баадай болон түүний гэр бүлийн ашиг сонирхлын зөрчил, авлигын эсрэг эрх зүйн баримт бичгийн эмхтгэл, “Мэдүүлэг гаргагчид зориулсан гарын авлага”, “Ашиг сонирхлын зөрчлийн мэдлэг, ойлголтыг олон нийтэд түгээн таниулах ажлын гарын авлага” зэрэг ном, зурагт хуудас, боршур зэргийг алба хаагч болон иргэд олон нийтэд тараасан.

Цагдаагийн газрын 1 дүгээр давхарт буюу “Иргэдийн танихм”-д Авлигын эсрэг хууль, хөтөлбөр болон тус цагдаагийн газраас авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээг сурталчилах булан, самбар гаргаж холбогдох мэдээлийг байршуулж тухай бүр шинэчлэн ажиллаж байна.

Цагдаагийн газрын эрх бүхий албан тушаалтан нар нь Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, тэдгээртэй холбоотой бусад хууль тогтоомж, шийдвэрийг алба хаагчдад таниулах, авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 3 удаагийн сургалт, мэдээллийг алба хаагчдад зохион байгуулсан.

Тус цагдаагийн газар нь Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/135 дугаар тушаалаар баталсан 160 орон тооноос 2018 оны жилийн эцэст буюу ХАСХОМ-ийн мэдүүлэг гаргах хугацаанд 158 алба хаагчтайгаар хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан.

Тухайн 158 алба хаагчдаас Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 20 дугаар тогтоолын хавсралтанд заагдсан Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагч 78 албан тушаалтнуудын ХОСХОМ-ийг <https://meduuleg.iaac.mn> цахим системд 2019 оны 01 дүгээр сарын 05-ны дотор бүрэн оруулж баталгаажуулсан.

Мэдүүлгийн тайлан мэдээг үнэн зөв гаргаж хуульд заасан хугацаанаас өмнө маягтын дагуу Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлж, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авсан тухай болон бусад холбогдох бүртгэлийг бүрэн хөтлөн ажилласан.

Тус цагдаагийн газрын эрх бүхий албан тушаалтан нар нь мэдүүлгийн бүрдүүлэлтийн програм дахь “ЭБАТ” цэсний бүрдүүлэлтийг тухай бүр тогтоомол, тасралтгүй бүрэн хөтлөж ямар нэг зөрчил дутагдалгүй ажиллаж байна.

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаатай холбоотой тайлан, мэдээг тогтоосон хугацаанд Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/45, Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан "ХАСХОМ-1" буюу "ХАСХОМ-ийн 2019 оны үйл ажиллагааны тайлан"-гийн маягт, Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/122 дугаар тушаалын 3, 4 дүгээр хавсралтаар шинэчилэн батлагдсан "ХАСХОМ-2" маягтын дагуу нэгтгэн Аюулгүй байдлын хэлтэст тогтоосон хугацаанд тайлагнасан.

Мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хянах эрх бүхий албан тушаалтнууд Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны 91 дүгээр тушаалын 4, 5, 6 дугаар хавсралтад зааснаар



"ХАСХОМ хүлээн авсан бүртгэл", "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн бүртгэл", "Мэдэгдэл, тайлбар тэдгээрийн шийдвэрлэлтийн бүртгэл"-ийг тус тус маягтын дагуу цаасан болон цахим хуудсны "ЭБАТ" цэсэнд бүрэн тусгаж, бүртгэн ажилласан.

Энэ оны эхний 3 дугаар улирлын байдлаар албан тушаал дэвшсэн, шилжин болон шинээр томилогдсон 8 алба хаагчийн ХАСХОМ-ийг хуульд заасан хугацаанд <https://meduuleg.iaac.mn> цахим системд оруулж баталгаажуулсан

Байгууллагын ил тод байдлыг хангах зорилгоор цагдаагийн газрын [www.uvs.police.gov.mn](http://www.uvs.police.gov.mn) хаяг бүхий цахим хуудас, "Увс цагдаагийн газар" нэртэй facebook хуудсанд үйл ажиллагаа, алба хаагчийн ёс зүйн дүрэм, байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм заавар, гомдол мэдээлэл хүлээн авах албан тушаалтны мэдээлэл, үйл ажиллагааны тайлан, цагдаагийн газрын даргын тушаал, Шилэн дансны мэдээлэл зэрэг нууцын зэрэглэлтэйгээс бусад материалыг байршуулсан.

Мөн 2019 оны бензин шатахуун, шатах тослох материал худалдан авах нээлттэй тендер заралж орон нутгийн "МВС", "УВС" телевиз, сангийн яамны [www.e-procurement.mn](http://www.e-procurement.mn) болон байгууллагын цахим хуудсанд тендерийн урилгыг олон нийтэд зарлан мэдээллэх ажлыг илт тод, нээлттэй зохион байгуулан ажилласан.

Мөн цагдаагийн газрын дэд даргын хяналтанд алба хаагчдын хүнд суртал, хээл хахууль, авлига, ашиг сонирхолын зөрчилтэй холбоотой мэдээллийг ажлын цагаар авах 70194802 дугаарын утасыг ажиллуулж байна.

Үүний үр дүнд энэ оны эхний 3 дугаар улирлын байдлаар тус цагдаагийн газрын алба хаагчдаас авлига, ашиг сонирхолын зөрчил, шан харамж, хээл хахуультай холбоотой гомдол мэдээлэл ирээгүй, мөн алба хаагчид энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилд холбогдоогүй болно.

#### *1.9. Алба хаагчдын үйл ажиллагаатай холбоотой иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, тэдгээрийн шийдвэрлэлтийн талаар:*

Иргэд, байгууллагаас цагдаагийн газрын үйл ажиллагаа, алба хаагчидтай холбоотой 12 гомдол, мэдээлэлд нийт 24 алба хаагч холбогдсон байна.

Гомдол мэдээлэлд холбогдсон алба хаагчдын 4 буюу 16.6 хувь нь ЦАХ-ийн харилцааны ёс зүй зөрчсөн, 1 буюу 4.1 хувь нь ажлын хариуцлага алдсан, 2 буюу 8.3 хувь нь архидан согтуурсан, 17 буюу 70.8 хувь нь ЭХХШТХ болон бусад хууль дүрэм зөрчсөн гомдол мэдээлэлд шалгагдсан байна.

Мөн гомдол мэдээлэлд холбогдсон алба хаагчдын 19 буюу 79.1 хувь нь офицер, 5 буюу 20.9 хувь нь ахлагч байна.

Алба хаагчдын үйл ажиллагаатай холбоотой иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, бүрийг хүлээн авч бүртгэлд оруулж, холбогдох албан тушаалтан албаны шалгалт явуулж, гэмт буруутай нь тогтоогдсон 2 алба хаагчийг албанаас халж, 1 алба хаагчид цагдаагийн цол бууруулах, 11 алба хаагчид сарын үндсэн цалинг бууруулах, 1 алба хаагчид "сануулах" сахилгын шийтгэл оногдуулж, 1 гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр шилжүүлж, 8 алба хаагчид холбогдох гомдол нотлогдоогүй үндэслэлээр тус тус хуулийн хугацаанд шийдвэрлэн гомдол гаргагчид хариуг 100 хувь бичгээр өгч ажилласан.

Алба хаагчдын үйл ажиллагаатай холбоотой иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, тэдгээрийн шийдвэрлэлтийн мэдээг сар бүрийн 25-ны дотор ЦЕГ-ын Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлэн ажиллалаа.

1.10. Алба хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйн чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ

Алба хаагчдаас 2019 оны эхний 3 дугаар улирлын байдлаар 30 зөрчилд давхардсан тоогоор 30 алба хаагч холбогдож, сахилгын арга хэмжээ авагдсан байх ба үүнээс 6 алба хаагч давтан зөрчил гаргасан байна.

Зөрчил гаргасан алба хаагчдыг албан тушаалаар нь авч үзвэл цагдаагийн газрын дарга 1, дэд дарга 1, тасгийн дарга 1, хэсгийн дарга 1, эрүүгийн мөрдөгч 4, хэсгийн төлөөлөгч 8, жижүүрийн ахлах мөрдөгч 1, жижүүрийн мөрдөгч 2, замын цагдаагийн зохицуулагч 5, аж ахуйн ажилтан 1, хэсгийн цагдаа 2, эргүүлийн цагдаа 1, бусад цагдаа 2 байна.

Сахилга ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчдын 25 буюу 83.3 хувь нь офицер, 5 буюу 16.7 хувь нь ахлагч бүрэлдэхүүн эзэлж байна.

Сахилгын зөрчлийн 9 буюу 30 хувийг дотоод хяналтаар, 3 буюу 10 хувийг ЦЕГ-ын Аюулгүй байдлын хэлтэс, ХШДАХэлтэс, 6 буюу 20 хувийг иргэд байгууллагын гомдол, мэдээллээр, 10 буюу 33.3 хувийг төрийн болон төрийн бус байгууллагаас ирүүлсэн албан бичгээр тус тус илрүүлсэн байна.

Сахилгын зөрчил гаргасан алба хаагчдаас 3 буюу 10 хувьд нь сануулах, 17 буюу 56.6 хувьд нь албан тугаалын сарын үндсэн цалинг бууруулах, 2 буюу 6.6 хувьд нь албан тушаал бууруулах, 4 буюу 14.8 хувьд нь цагдаагийн цол бууруулах, 4 буюу 13.3 хувьд нь цол бууруулах, 2 буюу 6.6 хувьд нь цагдаагийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах, 2 буюу 6.6 хувьд нь албанаас халах сахилгын шийтгэл тус тус оногдуулсан байна.

Цагдаагийн газрын алба хаагчдын 2019 оны эхний 3 дугаар улиралд гаргасан сахилга, ёс зүйн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг судлахад зөрчил гарахад нөлөөлсөн дараах шалтгаан нөхцлүүд байна гэж үзлээ. Үүнд:

1. Алба хаагчид согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэх явдал нь гэмт хэрэг, зөрчил болон сахилга ёс зүйн зөрчил үйлдэх гол шалтгааны нэг болж байна.

2. Нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагааг хуульд заасан үндэслэл журмын дагуу хэрэгжүүлээгүйн улмаас хуурамч нотлох баримт бүрдүүлэх гэмт хэрэг үйлдэлд холбогдож байна.

3. Соёл, соён гэгээрүүлэх ажил, алба хаагчдад чиглэсэн спортын уралдаан тэмцээнийг зохион байгуулдаггүй.

4. Алба хаагчид өөрсдөө бие дааж мэдлэг ур чадвараа дээшлүүлдэггүй.

5. Хувь хүний төлөвшил, хандлага, мэргэжлийн ур чадвараас шалтгаалан сахилга ёс зүйн зөрчил гаргаж байна

6. Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлдэггүй.

7. Албанд хандах хандлага сул

8. Алба хаагчдын нэгдмэл, эвсэг уур амьсгал, хамт олонч байдал хангалтгүй.

9. Офицер алба хаагчдын манлайлал маш сул

10. Ахлах албан тушаалтнуудын албаны зарчимч шаардлага, хяналт сул

11. Гэр бүлийн байдлаар тогтворгүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахууны хэм хэмжээг дагаж мөрддөггүй.

12. Нийтийг хамарсан арга хэмжээнд идэвхи санаачлагагүй оролцдог

13. Албаны нууцлал, цагдаагийн алба хаагчийн сэтгэлгээ сул зэрэг шалтгаан нөхцөл байна.

Цагдаагийн газрын алба хаагчдыг сахилга ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүй, ажлын хариуцлага, харилцааны соёлыг дээшлүүлэх, дээр дурдсан

шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн дараах ажил арга хэмжээг энэ оны эхний 3 дугаар улиралд зохион байгуулсан. Үүнд:

- Алба хаагчдаас 2018 онд гаргасан сахилга, ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөлийг судалж, тасгийн дарга нарт зөвлөмж хүргүүлсэн.
- Алба хаагчдын ажлын цаг ашиглалт, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор нүүр, хурууны хээ танигч төхөөрөмж суурьлуулж цаг бүртгэж хэвшсэн.
- Улирал бүр “Сахилга хариуцлагын зөвлөгөөн” зохион байгуулсан. Зөвлөгөөнийг шинэлэг хэлбэрээр буюу алба хаагчдыг 8 багт хувааж, сахилга ёс зүйн зөрчил гаргаж байгаа шалтгаан нөхцөл, түүнийг арилгах арга зам, цаашид хэрхэн сахилга ёс зүйн зөрчил гаргахгүй урьдчилан сэргийлэх талаар багаар ажиллуулж, багийн 1 гишүүнээр илтгүүлж, гаргасан санал, санаачлагыг хэрэгжүүлэхээр төлөвлөгөө боловсруулсан.
- Цагдаагийн газрын дарга алба хаагч нэг бүртэй “Итгэлцлийн гэрээ” байгуулсан.
- Алба хаагчдаас бичгээр баталгаа гаргуулан авсан
- Сахилга ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр сар бүр соён гэгээрүүлэх ажил, спортын уралдаан тэмцээн, сургалтыг зохион байгуулж, байгууллагын цахим хуудас болон фэйсбүүк хаягт байршуулсан.
- Дээд шатны байгууллагаас ирүүлсэн сахилга ёс зүйтэй холбоотой үүрэг, ажлын чиглэлийг алба хаагчдад тухай бүр танилцуулсан.
- Алба хаагчдын сахилга ёс зүй, байгууллага, алба хаагчийн аюулгүй байдалд өдөр бүр хяналт тавьж, ахлахаас дээш албан тушаалтан нар 24 цагаар “Ёс журам сахиулах эргүүл”-ийн үүрэг гүйцэтгэж байна.
- “Гэр бүлийн өдөрлөг” арга хэмжээг энэ оны 06 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулж, 141 алба хаагчдын гэр бүлтэй уулзаж, санал сэтгэгдэлийг нь хүлээн авсан.
- Сахилга ёс зүйд чиглэсэн “Төрийн алба хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтыг энэ оны 06 дугаар сарын 06-ны өдөр, Сэтгэл зүй ба гэр бүл” сэдэвт сургалтыг 06 дугаар сарын 11-ний өдөр, “Харилцааны соёл” сэдэвт сургалтыг 06 дугаар сарын 15-ны өдөр, “Байгууллагын соёл ба төлөвшил” сэдэвт сургалтыг 06 дугаар сарын 18-ны өдөр, “Ёс зүй ба харилцаа” сэдэвт сургалтыг энэ оны 09 дүгээр сарын 07-ний өдөр, нийт 5 удаагийн сургалтыг зохион байгуулсан ба давхардсан тоогоор 752 алба хаагч хамрагдсан.
- Цагдаагийн газрын даргаас энэ оны 06 дугаар сарын 21-ний өдөр алба хаагчдад сахилга ёс зүйн чиглэлээр ажлын чиглэл, үүргийг бичгээр өгч биелэлтийг нь сар бүр тооцон ажиллаж байна.

#### *1.11. Санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр:*

Тус цагдаагийн газар нь 2019 оны эхний 3 дугаар улиралд улсын төсвөөс 1729882,1 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлого 42994,8 мянган төгрөг тус тус батлагдаж, гүйцэтгэлээр 1,729,882,100 төгрөгийн санхүүжилт авч сар, улирлын хуваарийн дагуу алба хаагчдын цалин хөлс болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах тогтмол зардал, хангамж бараа материалын бусад зардлуудыг зардлын бүлэг тус бүрээр хянаж гүйлгээ хийж, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, авлага, өглөгийн мэдээг сар бүр гаргаж хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан.

Энэ оны тээвэр шатахуун нийлүүлэх нээлттэй тендер заралж, бичиг хэрэг, сэлбэг хэрэгсэл, барилгын жижиг засварын материал нийлүүлэх үнийн санал авч сонгон шалгаруулалт явуулан шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ажиллаж байна.

Мөн Төрийн өмчийн удирдлага мэдээллийн цахим ситемд 2018 оны үндсэн хөрөнгийн хөдөлгөөн шивж, ТӨХ, ТӨ тайлангуудыг гаргаж санхүүгийн тайлангийн хамт Орон нутгийн өмчийн газарт хүлээлгэн өгч баталгаажууллаа.

Энэ оны эхний 9 сарын байдлаар шилэн дансны нэгдсэн системд тус цагдаагийн газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, Аудитын байгууллагын дүгнэлт, 2019 оны 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 дугаар саруудын төсвийн орлого, зарлагын гүйлгээ, тендер, худалдан авалт, хөрөнгийн зарцуулалт, батлагдсан болон тодотгосон төсөв, бүтэц орон тоо, өглөг, авлагын талаарх мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон цагдаагийн газрын цахим хуудсанд тус тус байршуулж, 1, 2 дугаар улирлын тайланг цахимаар илгээж ажилласан.

ЦЕГ-ын ХШҮДАХ болон Санхүү, аж ахуйн албанаас ирүүлсэн шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой зөвлөмжийг хэрэгжүүлж, байгууллагын санхүүгийн ил тод байдлын мэдээллийн самбарт сар бүр тогтмол мэдээлэл байршуулах ажлыг хэвшүүлээд байна.

Шилэн дансны цахим системд санхүүгийн тайлан, аудитын байгууллагын дүгнэлтийг тус тус байршуулж, улирал бүр байршуулах 1 төрлийн 32 мэдээлэл, сар бүр байршуулах 3 төрлийн 33 мэдээлэл, тухай бүр байршуулах 8 төрлийн 88 мэдээллийг тус тус байршуулсан.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэдэх “Иргэний зөвлөл”-д 2018 оны жилийн эцэс, 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлтийг танилцуулж, иргэдэд “Нээлттэй хаалга”-ны өдөр болон “Шилэн данс” мэдээллийн самбараар мэдээлж, санхүүгийн танилцуулга бэлтгэж сум, багийн хурлын үеэр иргэдэд тарааж өгч ажиллалаа.

#### *1.12. Зохион байгуулсан шинэлэг ажил, арга хэмжээ:*

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагчийн шинэ санал, санаачлагыг дэмжих /код 116/ журам”-ыг хэрэгжилтийг хангах, цагдаагийн газрын алба хаагчдаас санаачилсан шинэ санал санаачлага, шинэлэг ажлыг дэмжин ажиллаж байна.

Энэ оны эхний 3 дугаар улирал тус цагдаагийн газар нь дараах шинэлэг ажил, арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:

- Орон байрны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хулгай ба гэр хорооллын хяналт 2019” арга хэмжээг зохион байгуулсан.
- Увс аймгийн Улаангом сумын 3 дугаар баг буюу орон сууцны хорооллыг бүхэлд нь буюу 15 цэгт 32 камер суурьлуулсан.
- Аймгийн Засаг даргын захирамж гаргуулж, төрийн байгууллагуудын ажилтан нарыг “Нийтийн эргүүл”-д ажиллуулж эхэлсэн.
- Олон нийтийн цагдаагийн ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Олон нийтийн цагдаагийн ажилтны нэгдсэн сургалт-зөвлөгөөн”-ийг зохион байгуулсан
- Аймгийн Засаг даргад хүмэлт хүргүүлж, долоо хоног бүрийн Баасан гарагт архи согтууруулах ундааны зүйл зарж, үйлчлэхийг хориглосон захирамж гаргуулсан.
- Алба хаагчдын “Сахилга, ёс зүйш дээшлүүлэх 45 хоногийн аян”-ыг эхлүүлсэн.
- Хүүхэд хамгаалах ажлыг хүртээмжтэй, үр дүнтэй зохион байгуулах зорилгоор аймгийн боловсролын байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг байгуулсан зэрэг шинэлэг ажил, арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

**Хоёр: Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ:**

## 2.1. Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр:

Энэ оны 10 дугаар сарын 01-ны өдрийн байдлаар гүйцэтгэх ажлын шугамаар нийт 429 мэдээ, мэдээлэл олж ЭЦА-ны ТТБ-ын санд оруулан баримтжуулан шалгасан ба өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад авсан мэдээлэл 224 нэгжээр буюу 1.2 дахин, туслах хүчээс авсан мэдээлэл 29 нэгжээр буюу 26 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Тус цагдаагийн газрын гүйцэтгэх ажилтнуудын энэ оны 09 дүгээр сард авсан мэдээллийг Завхан аймаг дахь Цагдаагийн газрын ЭЦТ-ийн алба хаагчидтай хамтран ГА-ын идэвхтэй арга хэмжээ зохион байгуулан шалгаж Увс аймгийн Тэс сум болон Завхан аймгийн харъяат малын хулгайн гэмт хэрэг үйлддэг сэжигтэй этгээдүүдийн үйлдсэн иргэдэд 49,3000,000 төгрөгний хохирол учруулсан, 53 тооны адуу хулгайлсан 6 холбогдогчтой 3 хэргийг илрүүлсэн ба үүнээс 18 адуу бусдад зарагдсан байсныг Тэс, Зүүнговь сумаас зүсээр олж тогтоон Завхан аймаг дахь Цагдаагийн газарт харъяаллын дагуу шилжүүлсэн.

Энэ оны эхний 10 сарын байдлаар иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 534,444,004 төгрөгний хохирол учруулсан 145 холбогдогчтой 121 хэрэг, үйлдэл илрүүлсэн шалгасан байна. Үүнийг урьд оны мөн үетэй харьцуулахад илрүүлсэн хэрэг, үйлдэл 36 нэгж буюу 29 хувиар өссөн байна.

Цагдаагийн газраас эрэн сурвалжлах “ASAP” сан ашиглалтанд орсноос хойш нийт 129 хүн, мал, эд зүйлийн мэдээллийг санд оруулан эрэн сурвалжилж 114 хүн, мал, эд зүйлийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоосон.

Тайлангийн хугацаанд тус Цагдаагийн газраас “ASAP” сангаар эрэн сурвалжлагдаж байсан гэмт хэрэгт сэрдэгдсэн 19, оргодол 9, оршин суугаа газраасаа алга болсон 28, шүүхээс даалгасан 8 хүн, 2 тээврийн хэрэгслийг тус тус олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоосон. Тус газрын алба хаагчид энэ оны эхний 3 дугаар улирлын байдлаар нийт 29662 эрэн сурвалжлалттай танилцан ажилласан байна.

Олон тооны мал хулгайлсан гэмт хэрэг үйлдэж Архангай аймаг дахь Цагдаагийн газраас эрэн сурвалжлах “ASAP” сангийн 5412030140000009 дугаараар 2014 оноос хойш буюу нийт 5 жил эрэн сурвалжлагдаж байсан Г.Отгонбаярыг Увс аймгийн Тариалан сумын нутаг дэвсгэрт байрлах “Бор хавцал” гэх газарт гар аргаар алт олборлохоор ирсэн тухай мэдээлэл авч 2019 оны 05 дугаар сарын 16-ны өдөр дайчлан баривчилж Архангай аймаг дахь Цагдаагийн газрын алба хаагчдад хүлээлгэн өгч ГА-ын мөрдөн сурвалжлах хэрэг болон хэрэг бүртгэлтийн хэргийг нь шийдвэрлүүлсэн.

Эрүүгийн цагдаагийн албаны Эрэн сурвалжлах хэлтсээс цагдаагийн газар, хэлтсүүдийн эрэн сурвалжлах ажлыг нэгтгэн дүгнэж байр эзлүүлсэн ба тус Цагдаагийн газар улсын хэмжээнд 91.1 оноотой 2 дугаар байр, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдээс 1 дүгээр байр эзэлж дүгнэгдсэн.

Тус цагдаагийн газрын эрүүгийн мөрдөгчид нь энэ оны эхний 3 дугаар улирлын байдлаар иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 383 гомдол, мэдээлэл хүлээн авч 187 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 91 гомдол, мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 15 гомдол, мэдээллийг харъяаллыг дагуу шилжүүлж, 93 гомдол, мэдээлэлд Зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ авч шийдвэрлэсэн гомдол гаргагчид 100 хувь хариуг өгч ажилласан.

Улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “Илрүүлэлт-Оргодол-Шийдвэрлэлт” нэгдсэн арга хэмжээг хариуцсан нутаг дэвсгэртээ зохион явуулах удирдамж төлөвлөгөөг боловсруулан цагдаагийн газрын даргаар батлуулж биелэлтийг нь хангуулан ажиллаж байгаа бөгөөд эрүүгийн 1 мөрдөгчийг эрэн сурвалжлах ажлаар Улаанбаатар хотод томилолтоор ажиллуулж байна.

## *2.2. Мөрдөн байцаах албаны чиглэлээр:*

Энэ оны 3 дугаар улирлын байдлаар гэмт хэргийн шинжтэй 142 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 43 гомдол мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 90 гомдол мэдээллийг хэрэг бүртгэлтийн /мөрдөн байцаалт/ хэрэг нээж, 5 гомдол мэдээллийг харъяаллын дагуу шилжүүлж, одоо 4 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй байна.

Мөн хугацаанд 198 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулснаас 89 хэргийг хаах саналтай, 4 хэргийг харъяаллын дагуу шилжүүлэх саналтай, 81 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт хүргүүлж шийдвэрлэсэн ба одоо ажиллагаанд 24 хэрэг шалгагдаж байна.

Дээрх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргүүдийг нэн даруй, тэр даруй хугацаанд нь тухай бүр нь гэмт хэргийн мэдээллийн санд бүртгэж, тасгийн даргын зүгээс цаасаар болон цахим сангийн орчинд тогтмол тулгалт тавьж ажилласнаар буруу оруулсан, дутуу шивсэн зөрчил арилсан.

Гэмт хэрэг үйлдэгдсэн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар 148 мөрдөгчийн мэдэгдэл бичиж 100 хувьд нь хариуг авсан байна.

Цагдаагийн газраас “ASAP” сангаар эрэн сурвалжлагдаж байсан гэмт хэрэгт сэрдэгдсэн 6, оргодол 1 тус тус олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоосон.

Сар бүр аймгийн Прокурорын газартай зөвлөгөөн зохион байгуулж, тухайн сард шийдвэрлэх хэргийн график төлөвлөгөөг гарган Мөрдөн байцаах албанд хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

## *2.3. Хэрэг бүртгэх албаны чиглэлээр:*

Хэрэг бүртгэх тасаг нь энэ оны эхний 3 дугаар улирлын байдлаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11 дүгээр бүлгийн 11.1 дүгээр зүйлийн 2.5 дахь хэсэгт зааснаас бусад энэ бүлэгт заасан гэмт хэргийн талаарх 125 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан.

Нийт 104 хэрэг бүртгэлтийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 12 хэргийг хаах саналтай прокурорт хүргүүлж, 83 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж, одоо ажиллагаанд 9 хэрэг шалгагдаж байна.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан 83 хэргийн 78 хэргийг буюу 93.9 хувийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт хүргүүлж шийдвэрлэсэн.

Хэрэг бүртгэх албаны даргаас энэ оны 02 дугаар сарын 28-ний өдөр 12/269 дугаар албан бичгээр ирүүлсэн ажлын чиглэлийн дагуу “Нэг хором” аяныг зохион байгуулан ажилласан.

Энэ оны 03 дугаар сард аймгийн ЗДТГ-ын “Олон нийтийн оролцооны танхим”-д төрийн байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөний үеэр болон тус аймгийн “Увс цахилгаан холбоо” ХХК-ний ажилчид, Хөдөлмөрийн дээд сургууль, Улаангом коллежийн оюутан залуучуудад “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг” гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалт хийж, цагдаагийн байгууллагаас зохион явуулж байгаа “Нэг хором” аяныг сурталчилж, өнгөрсөн онд цагдаагийн байгууллагаас зохион явуулсан “Хуулийн хэрэгжилт” нэгдсэн арга хэмжээний хүрээнд бэлтгэж ирүүлсэн 8 төрлийн контент, шторкыг үзүүлж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулсан.

ЦЕГ-ын Хэрэг бүртгэх албанаас ирүүлсэн “Ухаалаг залуус амьдрал аварна”, “Нэг цохилт, хоёр амьдрал” зурагт хуудсыг дээрх байгууллагуудад хүлээлгэн өгч, сургалтад

хамрагдсан ажилчдад “Ухаалаг залуус амьдрал аварна” жижиг зурагт хуудас тарааж ажилласан.

“Нэг хором” аяны хүрээнд “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг” гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр энэ оны 03 дугаар сарын 07-ны өдөр орон нутгийн “МВС”, “Увс нам бус” телевизүүдээр сэрэмжлүүлэг, мэдээлэл хийсэн.

Хэрэг бүртгэх албаны ДШҮХШХ-ийн даргын энэ оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 12б/1013 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Хүүхэд” арга хэмжээний хүрээнд дараах ажил арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Үүнд:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/51, А/69 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам”-ын 4.3 дэх хэсэгт заасан албан тушаалтнууд буюу аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүдэд 09 дүгээр сарын 13-ны өдөр аймгийн Засаг даргын тамгын газрын “Олон нийтийн оролцооны танхим”-д чадавхжуулах сургалт зохион байгуулж, арга зүйгээр ханган ажилласан.

Аймгийн төвийн Ерөнхий боловсролын 6 сургуулийн 8-12 дугаар ангийн 1896 сурагчдад эрсдэл бүхий нөхцөл байдал, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан.

Дээрх үйл ажиллагааны мэдээллийг “Увс аймаг дахь цагдаагийн газар” facebook хаяг, [www.uvs.police.gov.mn](http://www.uvs.police.gov.mn) цахим хуудсанд байршуулан ажилласан.

### *2.3. Нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр:*

Энэ оны эхний 3 дугаар улирлын байдлаар Увс аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхээр 336 шүүх хурал, Захиргааны хэргийн анхан шатны шүүхээр 20 шүүх хурал, эрүүгийн хэргийн шүүхээр 231 шүүх хурал, захиргааны зөрчлийн 167 шүүх хурал, эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх хурал 14, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх хурал 13 нийт 781 шүүх хурлын хамгаалалтад хамгаалалтын 2 цагдаа үүрэг гүйцэтгэж шүүх шүүгчийн аюулгүй байдал, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг ханган шүүх хуралдааны танхимд үзлэг шалгалт хийн шүүн таслах ажиллагаа явуулах хэвийн нөхцөлийг бүрдүүлэн шүүх хуралдааны тогтоосон дэгийг сахиулан ажилласан байна.

Шүүхийн байрнаас, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны цагдан хорих байр хүртэл ялтанг жижүүрийн албаны автомашинтайгаар хуяглан хүргэх ажиллагааг ердийн болон хүч нэмэгдүүлэн зохион байгуулан ажиллаж байна.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид энэ оны эхний 3 дугаар улирлын байдлаар давхардсан тоогоор Увс аймгийн сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Увс аймгийн Давж заалдах шатны шүүхээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны цагдан хорих байранд 68 удаагийн хуяглан хүргэлтээр 56 шүүгдэгч, яллагдагч, ялтанг хүлээлгэн өгч ажилласан.

Хуяглан хүргэх ажиллагааны өмнө шүүгдэгч, яллагдагч, ялтныг хүлээн авахдаа шүүх хуралдааны тов, шүүхэд дуудах хуудсын дагуу овог, нэрээр тулган хүлээн авч, хувцас болон бие, эд зүйлд үзлэг хийн, хориотой эд зүйл байгаа эсэхийг үзэж шалган, шүүх хуралдааны журам сахиулагч болон хорих анги, цагдан хорих байрны жижүүртэй шүүгдэгч, яллагдагч, ялтныг бүртгэлээр хүлээлцэж, түр саатуулах байранд байрлуулах, автомашинаар хуяглан хүргэх явцдаа нэг бүрийн тусгай хэрэгсэл гав хэрэглэн хуяглан хүргэж байна.

Увс аймаг дахь иргэн, эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Увс аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн байрны аюулгүй байдлыг ханган учирч болох

гэмт халдлагаас урьдчилан сэргийлэн харуулын цагдаа нар 273 удаа жижүүрийн үүрэг гүйцэтгэн 6652 цаг ажиллаж 1228 иргэний баримт бичиг холбогдох эд зүйлд үзлэг шалгалт хийж шүүхийн байранд нэвтрүүлж шүүх хуралдааны танхимд үзлэг шалгалт хийн шүүн таслах ажиллагаа явуулах хэвийн нөхцөлийг бүрдүүлэн шүүх хуралдааны тогтоосон дэгийг сахиулж ажиллаж байна.

Тус газрын албадан эрүүлжүүлэх, саатуулах байр нь 2019 оны эхний 3 дугаар улирлын байдлаар эрүүлжүүлэгдсэн 980 саатуулагдсан 231 нийт 1211 хүнээс Хууль зүй дотоод хэргийн сайд, Сангийн яамны сайдын 2007 оны 58/62 дугаартай хамтарсан тушаалаар батлагдсан. Эрүүлжүүлэх үйлчилгээний хөлс болох нийт 5025650 төгрөгийг 100 хувь хураан авч төрийн сангийн дансанд тушааж санхүүтэй тооцоо хийсэн.

Сум дундын шүүхийн шүүгчийн шийтгэврээр 179 иргэнийг 1858 ор хоног баривчлах байранд хүлээн авч, эдлүүлж 175 хүнээс 1750 ор хоног буюу 7036170 төгрөгийг хураан авч 150012001 тоот төрийн сангийн дансанд төвлөрүүлэн ажиллаж байна. Эрүүлжүүлэгдсэн, баривчлагдсан хүн нэг бүрд эрүүл мэндийн үзлэг хийж 61 хүнд хордлого тайлах, артерийн даралт буулгах, цус тогтоох, өвчин намдаах, зэрэг эмнэлгийн анхны тусламж үзүүлж эмчлүүлэх боломжоор ханган, иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэн ажилласан.

Баривчлагдсан иргэдийг албадан сургалтанд хамруулах ажлыг ГБХЗХГ-тай хамтран хэрэгжүүлж төлөвлөгөөг хагас жилээр гаргаж, баривчлагдсан болон эрүүлжүүлэгдсэн, саатуулагдсан этгээдэд архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, зөрчлийн тухай хуулийн холбогдох заалт болон шинээр гарсан хууль тогтоомжийг сурталчилж архи, тамхины хор хөнөөл, архинаас ангижрах арга замын талаар “Зөрчлийн тухай хууль” 5.4.4.1-р “Гэр бүлийн хүчирхийлэл ГБХХГХУС мэргэжилтэн, сэтгэл зүйч,” “Зөрчлийн тухай хууль 14.7-р “Замын хөдөлгөөний аюулгүй байдал ЗЦТ-ын алба хаагч нар “Зөрчлийн тухай хууль” 8.6-р “Хулгайлах” “Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн гарзны мэргэжилтэн “Зөрчлийн тухай хууль” 5.2,5.3 хэсгийн байцаагч нар албадан сургалт, яриа таниулга хийж өрөө тус бүрт байршуулсан өсгөгч, чанга яригчаар сэрэмжлүүлэг, шторкыг тодорхой цагуудад тогтмол явуулж хэвшсэн бөгөөд 2019 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 179 хүнийг 2190 цагийн албадан сургалтанд хамруулсан байна.

Баривчлагдсан хүн нэг бүрт хувийн хэрэг нээж, гарын хээний дардас, фото зургийг хавсаргаж хууль эрх зүйн зөвлөгөө өгч, тойрох хуудас баривчлах байрны шууд зардлын тооцоог гаргаж нэг хүнд ногдох хоногийн хоолны илчлэг 2800ккл-аар тооцож өдөрт 2 удаа халуун хоол, 2 удаа буцалсан ус, халуун, хүйтэн цай талхаар үйлчилж телевиз, ном сонин, шатар, даам зэрэг чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, угаалгын машинд хувцас цэвэрлэх, усанд орох, ар гэрээсээ эргэлт авах, ар гэртэйгээ утсаар ярих зэрэг нөхцөлөөр ханган ажилласан.

Эрүүлжүүлэх, баривчлах байранд 7 хоногт 2 удаа их цэвэрлэгээ хийж, өдөр бүр жавелионтой, уусмалаар ариутган, хучлага дэвсгэрүүдэд хортон шавьжийн ариутгалыг “АРИУСАХУЙ” ЗБН хамтран гэрээг байгуулж гэрээний дагуу 2 удаа хийлгүүлсэн. Эмч, цагдаа нарыг цагдаагийн газрын дотоод журамд заагдсаны дагуу жагсаалын үзлэг мэдээллийн цаг, албаны сургалт, спортын арга хэмжээ, хүч нэмэгдүүлсэн эргүүлд бүрэн ажиллаж байна

Эргүүлийн чиглэлийг оновчтой зохион байгуулах зорилгоор 2018 оны эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд тулгуурлан 2019 оны эргүүлийн нэгдсэн байршилтыг тухайн улирлын онцлогт тохируулан улирлын байдлаар боловсруулж, эрүү, хэв журмын нөхцөл байдалтай холбогдуулан эргүүлийг өдөр, орой, шөнийн цагийн хуваарийн дагуу явган болон автомашинтайгаар давхардсан тоогоор 1810 алба хаагч 720 нийтийн эргүүлтэйгээр зохион байгуулж ажилласан.



Тус тасаг нь эргүүлийн 12 алба хаагчийн орон тоотой бөгөөд энэ онд жилийн хугацаанд 11 алба хаагч ажиллаж 2120/16960 хүн цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж, эргүүлийн үр дүнд 115 зөрчил илрүүлж ажиллаж, 861 дуудлага мэдээлэл хүлээн авсанаас 243 гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй байсан. Энэ хугацаанд 302 хүнийг саатуулах байранд, 446 хүнийг ар гэр, асран хамгаалах хүнд хүлээлгэн өгч, 51 удаа хамгаалалт хийж ажилласан байна.

Тус цагдаагийн газраас Монгол банкны Увс аймаг дахь салбартай 2019 онд хамтран ажиллах гэрээг шинэчилэн байгуулж, харуулд ажиллах 4 алба хаагчийн үйл ажиллагааны зардал, төсвийг хүргүүлэн, тогтвор сууршилтай ажиллуулж байна.

НХЖХТ-ийн дарга гэрээт цагдаа нарын хоногийн нөхцөл байдлын илтгэх хуудас, албаны галт зэвсгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтанд өдөр бүр хяналт тавьж, удирдлагаар ханган ажиллаж байна.

2019 оны эхний 3 дугаар улирлын байдлаар Монгол банкны салбарт 378 хүн нэвтэрхэд бичиг баримт, эд зүйлд үзлэг хийж, ХААН банк 33, Хас банк 20, Төрийн банк-53, Голомт банк 35 удаа зузаатгал авах үеийн хамгаалалтыг зохион байгуулсан. Монгол банкны төв салбараас 2019 оны эхний 3 дугаар улирлын байдлаар 2 удаа зузаатгал хийгдэхэд хамгаалалт хийсэн.

Банкны байрны аюулгүй байдал дохиолол, хяналтын камер, утаа мэдрэгч зэргийг өдөр бүр тухайн өдрийн ёс журам сахиулах эргүүл, ерөнхий жижүүр хамт шалгаж бичгээр үүрэг чиглэл өгсөн.

Гэрээт болон хувийн хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй 3 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байгаагаас SAS програмд 3 хамгаалалтын алба байгууллагын мэдээлэлийг бүрэн шивж бүртгэлийн дугаар авч үйл ажиллагаа явуулж байна. Гэрээт болон хувийн хамгаалалтын үйл ажиллагааг давхардсан тоогоор 3 удаа шалгаж заавар, зөвлөгөө өгч биелэлтийг тооцож ажилласан.

#### *2.4. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны чиглэлээр:*

Увс аймгийн болон аймгийн төв, сумдын нутаг дэвсгэрийг бүслэн хаах төлөвлөгөө, Онцгой нөхцөл байдал үүссэн үед Хил хамгаалах, Тагнуул, Онцгой байдлын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран ажиллах төлөвлөгөө, Гал түймэр гарсан үед байгууллагыг авран хамгаалах, Тэсэрч дэлбэрэх бодис, химийн хорт бодистой холбоотой дуудлага мэдээлэл ирсэн үед ажиллах, Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед ажиллах, Гамшгийн нөхцөл байдал үүссэн, онц байдал зарласан үед ажиллах төлөвлөгөөнүүдэд тодотгол хийж батлуулан ажиллаж байна.

2019 оны эхний 3 дугаар улирлын байдлаар гадаад орны өндөр, дээд хэмжээний зочин төлөөлөгч “Швейцарын Холбооны Улсын Үндэсний зөвлөлийн дарга, хатагтай Марина Кароббио 2019 оны 06 дугаар сарын 26-30-ны өдрүүдэд зочилсон ба Увс аймагт зочлох үеийн аюулгүй байдлыг хангах хамгаалалтын салбар төлөвлөгөө, ажил үүргийн хуваарь”-ийг гаргаж цагдаагийн газрын даргаар батлуулж хэв журмын хамгаалалтыг ямар нэг нь зөрчил дутагдалгүй зохион байгуулж ажиллаа.

Тус аймагт 2019 оны эхний 3 дугаар улирлын байдлаар, нийтийг хамарсан арга хэмжээний дараах хамгаалалтыг зохион байгуулан ажилласан байна. Үүнд:

Завхан суманд зохион байгуулагдсан “Тэмээ-мөс-загасчлах”, аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион явуулсан “Цасны баяр”-ын арга хэмжээний хамгаалалт, зохицуулалтанд батлагдсан зураглал, төлөвлөгөөний дагуу гэмт хэрэг зөрчилгүй зохион байгуулж, танилцуулгыг Нийтийн хэв журам хамгаалах, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны даргад хүргүүлсэн.

Монголын уламжлалт сар шинийн баярт зориулсан хүчит бөхийн барилдаан, шашин номын цэнгүүн, Сар шинэ үзэсгэлэн худалдаа, Peking to Paris нэртэй сонгодог машинуудын уралдаан, Улсын баяр наадам, Баруунтуруун сумын 60 жилийн ой, Өлгий сумын 60 жилийн ой, Баруун бүсийн даншиг наадам, “Түмэн тэмээний баяр, “Цагаан толгойн овоо”-ны тахилга наадам зэрэг томоохон арга хэмжээнүүдэд хүн, хүч хэрэгслийг тооцож, дүрэмт хувцсыг цаг агаарын байдалд тохируулан жигдрүүлж, алба хаагч нэг бүрийг тусгай хэрэгсэл, радио станцаар хангаж, алба хаагчдын сахилга, ёс зүй, харилцаанд анхаарч, албан үүрэг гүйцэтгэхдээ “Цагдаагийн байгууллагын ажил, үйлчилгээний стандарт”-ыг мөрдөж ажиллах, байгууллагын аюулгүй байдал, нууцын хадгалалт хамгаалалтанд онцгой анхаарах, жижүүр, харуулын үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдыг тусгайлан үүрэгжүүлж бичгээр болон амаар үүрэг чиглэл өгч ажилласан.

Тус аймагт 2019 оны 3 дугаар улирлын байдлаар 5 удаа хурдан морины уралдаан зохион байгуулагдсан. Үүнд:

1. “Увсын хурд” морин спорт уяачдын холбооноос Улаангом суманд 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдөр Монгол улсын тод манлай уяач Бичээрэйн Далайгийн цолны мялаалга наадамд 6 насны 400 гаруй морь уралдаж 128 хүчит бөхийн барилдааныг зохион байгуулсан.

2. Увс аймгийн “Төвийн бүсийн хурдан морины уралдаан” 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулж уралдаанд Улаангом, Түргэн, Сагил, Наранбулаг, Өндөрхангай, Хяргас, Зүүнговь, Тариалан зэрэг 9 сумдын 400 гаруй морьд 6 насны ангилалд уралдсан.

3. Увс аймгийн Өмнөговь суманд “Баруун аймгийн бүсийн хурдан морины уралдаан” Өмнөговь сумын Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/44 дүгээр захирамжаар энэ оны 05 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулагдаж 6 насны 240 гаруй морьд уралдсан.

4. Цагаанхайрхан суманд аймгийн “Зүүн бүсийн хурдан морины уралдаан” 2019 оны 05 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулагдаж 4 насны 125 морь уралдсан.

5. Тэс суманд 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдөр сумын уяачдын холбооноос 6 насны 125 морины бооцоот уралдаан зохион байгуулагдсан.

Дээрх уралдааны хамгаалалтанд давхардсан тоогоор Нийтийн хэв журам хамгаалах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр 99 алба хаагч, 15 автомашин, 6 мотоцикльтой үүрэг гүйцэтгэсэн.

Тус аймагт 2019 оны 06 дугаар сарын байдлаар 4 удаагийн жагсаал цуглаан хийхэд хэв журам олон нийтийн аюулгүй байдлыг хангаж ажилласан. Үүнд

1. МАН-ын хорооноос 2019.02.24-ний өдөр Монгол ардын намын 98 жилийн ой болж байгаатай холбогдуулан Улсын их хурлын гишүүн Б.Чойжилсүрэн, Улсын их хурлын гишүүн, МУ-ын засгийн газрын гишүүн, сангийн сайд Ч.Хүрэлбаатар нар ирж ард иргэдтэй уулзалт зохион байгуулсан.

2. Увс аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч Ц.Батболд болон “Жирийн иргэдийн нэгдэл” ТББ-аас санаачилж Хүүхдийн хүчирхийллийн эсрэг “Гэрэл асаая” цуглааныг 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдөр орон нутгийн цагаар 10.00-12.00 цагийн хооронд маршал Ю.Цэдэнбалын талбайд тайван замаар жагсаал, цуглаан зохион байгуулсан.

3. Увс аймгийн Ардчилсан намын дарга Ч.Чимэдээс, “Хариуцлага нэхэх сөрөг хүчний” жагсаал цуглааныг 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдөр орон нутгийн цагаар 14.00-17.00 цагийн хооронд маршал Ю.Цэдэнбалын талбайд зохион байгуулсан

4. “Гулзатын санаачлага” төрийн бус байгууллагын төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Давааням “ Аймгийн Засаг дарга Д.Батсайхан буруу шийдвэр гаргаж менементийн гэрээг хууль бус “Гулзатын нөхөрлүүдийн холбооны” талд өгсөн гэх ”

нэрээр жагсаал цуглааныг 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдөр орон нутгийн цагаар 14.00-15.00 цагийн хооронд маршал Ю.Цэдэнбалын талбайд тус тус зохион байгуулсан.

Хамгаалалтанд цагдаагийн газраас давхардсан тоогоор 88 офицер, 145 ахлагч нийт 233 алба хаагч 15 автомашинтай эрүү, хэв журам, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, хамгаалалтанд үүрэг гүйцэтгэсэн ба Замын хөдөлгөөний хяналтын нэгдсэн систем буюу камераар цуглааны үйл ажиллагааг удирдлагын түвшинд хянаж, үүрэг чиглэлээр ханган ажилласан.

## 2.5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Тус цагдаагийн газраас эхний гуравдугаар улирлын байдлаар ЦЕГ-ын УСХ болон бусад албадаас ирүүлсэн удирдамжийн дагуу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран “Сар шинэ-2019”, “Нэг хором” аян болон орон нутгийн цаг үеийн нөхцөл байдалд уялдуулан “Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлье”, “Хурд”, “Тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэг, хэрэгсэл”, “Ачааны авто машин, ачаа тээвэрлэлт”, “Мотоцикл”, “Бяцхан зорчигч”, “Оюутан тээвэр”, “Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, “Байгалиа хамгаалъя”, “Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, “Бодис-2019”, “Зөв тусгал” аян, “Устгал 2019”, “Яараад яахавдээ”, “Орон нутгийн замын хөдөлгөөний соёл”, “Улсын дугаар 2019”, “Хичээлийн шинэ жил” зэрэг нэгдсэн арга хэмжээнүүдийн салбар төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн үр дүнг тооцон ажиллаж байна.

Гэмт хэргийн гаралтын шалтгаан нөхцлийг судлан тодорхойлсны үндсэн дээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хулгай ба гэр хорооллын хяналт 2019”, “Урамшуулалт эргүүл 2019”, “Шатахуун түгээх станц 2019”, “Орон нутгийн замын хөдөлгөөний хяналт”, “Сар шинэ хяналт шалгалт”, “Орон нутгийн замын хөдөлгөөний хяналт 2”, “Нийтийн эргүүл”-д ажиллуулах, “Насанд хүрээгүй хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлье”, “Эрх зүйн олимпиад”, “Малчин сумын эмэгтэйчүүдийн чуулган”, “Сагил сумын Малчдын зөвлөгөөн”, “Масс мессэж”, “Хотгорын уурхай хяналт шалгалт”, “Наурыз 2019”, “Замын хөдөлгөөний цагаан толгой”, “Хаврын нүүдэл”, “Сэжигтэй байр байгууламж”, “Акц”, “Захирамж тусгай зөвшөөрөл”, “Нээлттэй хаалганы өдөр”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэе”, “Бүлэг бөөгнөрөл”, “Намрын нүүдэл” зэрэг 28 хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах чиглэлээр мөрдөн байцаалтын шатанд 80 мэдэгдэл өгч 70 хариуг хугацаанд нь авч, хэрэг бүртгэлтийн хэрэгт 95 мэдэгдэл өгч 74 хариуг хугацаанд нь авсан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 486 мэдэгдэл бичиж, нийт 661 мэдэгдэл бичиж байгууллага, аж ахуйн нэгжид хүргүүлэн хяналт тавин 626 мэдэгдлийн хариуг хугацаанд нь авч биелэлтийг газар дээр нь 386 удаа шалгаж үр дүнг нь тооцсон. Одоогийн байдлаар 35 мэдэгдлийн хариу заагдсан хугацаандаа байгаа болно.

Энэ оны гуравдугаар улирлын байдлаар тус цагдаагийн газрын криминологи судалгааны баг сүүлийн 3 жилийн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээнд дүн шинжилгээ хийж 3 удаа хуралдаж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулах, эргүүлийн алба хаагч нарыг оновчтойгоор ажиллуулах талаар цагдаагийн газрын даргад санал оруулан шийдвэрлүүлсэн.

Гудамж талбайд үйлдэгдэх гэмт хэргийн гаралтыг бууруулах чиглэлээр аймгийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/103 тоот “Олон нийтийн эргүүл” ажиллуулах тухай захирамжыг гаргуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн ГХУСАЗСЗ-өөс орон нутгийн МВС телевизтэй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2019 онд хамтран ажиллах гэрээний төлбөр 1.000.000 төгрөгний зардал шийдвэрлэж өгсөн.

Тус цагдаагийн газраас “Нэг хором” аян, Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд Монгол улсын хүний эрхийн байгууллагын дэмжлэгтэйгээр аймгийн ГБХЗХГ, Нэгдсэн эмнэлэг, хүний эрхийн үндэсний комиссын Увс аймаг дахь ажилтантай хамтран “Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлье” нэгдсэн арга хэмжээг энэ оны 2 дугаар сард эхлүүлсэн бөгөөд 3 дугаар сард үргэлжлүүлэн Наранбулаг, Завхан, Өлгий, Өмнөговь, Ховд, Бөхмөрөн сумдад зохион байгуулан ажилласан. Энэ хугацаанд нийт 12 удаагийн сургалтад 380 гаруй иргэд, 650 гаруй сурагчид хамрагдсан байна. Мөн арга хэмжээний хүрээнд иргэд, хүүхдүүдийн дунд “АХА”, “Алтан хонх” тэмцээнүүдийг 12 удаа зохион байгуулж сумдын ГХУСАЗСЗ-өөс 180000 /нэг зуун наян мянга/ төгрөгийн шагналын зардлыг шийдвэрлүүлж, амжилттай оролцсон иргэд, хүүхэд залуусыг шагнаж урамшуулсан. Сумдад ажиллах үеийн бензин шатахууны зардал, иргэдэд кофе цайгаар үйлчлэх зардал болох 300000 /гурван зуун мянган төгрөг/ зардлыг Монгол улсын хүний эрхийн үндэсний комиссоос шийдвэрлэсэн.

Мөн Давст, Бөхмөрөн, Наранбулаг, Хяргас, Цагаанхайрхан, Зүүнхангай, Малчин, Ховд, Зүүнговь, Сагил, Тариалан сумдын алба хаагчид “Нэг хором” аяны хүрээнд иргэдийн олон улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг угтаж баяр амралтын өдрийг “Архинаас татгалзъя, уураа тэвчье” уриан дор “Сагс”, “Гар бөмбөг”, “Мөсний тэмцээн”, “Уран жолоодлого-1,2”, “Буудлага- 1,2”, “Дэвжээ”, “Масс мессеж”, “Хэн сайн дуулах вэ”, “Эмэгтэйчүүдийн чуулга уулзалт”, “Малчдын зөвлөгөөн” зэрэг арга хэмжээнүүдийг орон нутгийн удирдлагуудтай хамтран зохион байгуулж, төрийн байгууллагууд болон, сумдын ГХУСАЗСЗ-өөс 2140000 /хоёр сая нэг зуун дөчин мянга/ төгрөг шийдвэрлүүлсэн бол Цагаанхайрхан сумын ГХУСАЗСЗ-өөс хэсгийн төлөөлөгч, цагдаа нарт 1850000 /нэг сая найман зуун тавин мянга/ төгрөгийн үнэ бүхий мотоцикль шийдвэрлүүлснээр 3 сард тус цагдаагийн газрын алба хаагчид ГХУС ажилд 4470000 төгрөгний санхүүжилтийг орон нутгаас гаргуулан шийдвэрлүүлсэн байна.

Иргэдийн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр, Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийн хүрээнд Аймгийн ЗДТГ-ын ХЭЗ хэлтэс, Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Нэгдсэн эмнэлгийн даргын хамтран баталсан удирдамжийн дагуу “Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлье” нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион ажиллаж байна. Тус нэгдсэн арга хэмжээний хүрээнд аймгийн цагдаагийн газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэргэжилтэн, Увс аймаг дахь Хүний эрхийн ажилтан, Нэгдсэн эмнэлгийн өсвөр үеийн эмч, Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын мэргэжилтэн, Нийгмийн даатгалын хэлтсийн мэргэжилтэн нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Хяргас, Малчин, Зүүнговь, Тэс сумандын иргэдэд, эрх зүйн мэдлэг олгох, сурагчдад “Хүүхдийн эрхийг хамгаалах”, “Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулав.

Тус сургалтад дээрх сумдын 870 иргэн 765 сурагч нийт хүнийг хамруулж 1635 хүнд сургалт сурталчилгааны ажил зохион байгуулж, 1320 ширхэг зурагт хуудас материал тарааж 440.000 төгрөгний зардлыг шийдвэрлүүлэн ажиллалаа.

“Зөв тусгал” аяны хүрээнд бага насны хүүхдийг зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд оролцох боловсрол эзэмшүүлэх, замын хөдөлгөөний дүрмийг таниулах зорилгоор Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Боловсрол, соёл урлагийн газар, Улаан загалмайн

хороотой хамтран цэцэрлэгийн насны хүүхдүүдийн дунд “Замын хөдөлгөөний цагаан толгой” тэмцээнийг зохион байгууллаа. Тус тэмцээнд 10 цэцэрлэгийн 120 хүүхэд багачууд 20 багш болон эцэг эхийн төлөөлөл оролцсон. Тэмцээнд оролцсон хүүхдүүдийн шагнал урамшуулал болон оролцсон хүүхдүүдийн гарын бэлэгт зарцуулагдах 1.300.000 төгрөгийн зардлыг шийдвэрлүүлсэн.

Мал хулгайлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бүлэг нөхөрлөлийн гишүүдийн сургалт зөвлөгөөнийг зохион байгуулах саналыг аймгийн Засаг даргын тамгын газрын ХЭЗХ-т хүргүүлэн Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх дэд хөтөлбөрийн зардлаас 1500000 төгрөг шийдвэрлүүлсэн. Мөн Өсвөрийн сэргийлэгч 2019 бүлгэмүүдийн дундах тэмцээн зохион байгуулах удирдамж төлөвлөгөө боловсруулан аймгийн ГХУСАЗСЗ-д санал хүргүүлэн 250000 төгрөг шийдвэрлүүлсэн.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан нэгдсэн болон тусгай арга хэмжээ, өдөрлөг, аян, хэлэлцүүлэг, зөвлөгөөний явцад давхардсан тоогоор 550 алба хаагч 276 удаа 287 байгууллага, аж ахуйн нэгжийн 16870 хүнд сургалт, мэдээ мэдээлэл, яриа таниулгыг хийж, тэдгээрийн санал хүсэлтийг сонсож ажилласан.

Гэмт хэрэг үйлдэж болзошгүй сэжигтэй этгээдүүдийн үйл ажиллагаа, амьдралын хэв маяг, орлогын эх үүсвэр, хань харилцаа зэрэгт хяналт тогтоох зорилгоор тус аймгийн хэмжээнд урьд нь гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдэж суллагдсан, сэжиг бүхий байдлаар аж төрж буй 412 этгээдийн оршин суух хаягийг тогтоож тухайн газар нутаг хариуцсан хэсгийн төлөөлөгч, эрүүгийн мөрдөгч нарт хариуцуулан өгч хяналтанд авч ажиллаж байна. Эдгээр этгээдүүдийг бүрэн хяналтанд авах зорилгоор хүн нэг бүрийг тулгалт хийж 412 этгээдийн талаар мэдээ мэдээлэл агуулсан нэгдсэн сан үүсгэж үйл ажиллагаандаа ашиглаж байна. Дээрх этгээдүүдийн үйлдэж болзошгүй гэмт хэргийн төрлөөр нь авч үзвэл: Хулгайлах гэмт хэрэг үйлдэж болзошгүй 302, хүний амь бие, эрүүл мэндийн гэмт хэрэг үйлдэж болзошгүй 62, хүний бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг үйлдэж болзошгүй 48 этгээдүүдийг хяналтанд аваад байна.

Тус цагдаагийн газар нь орон нутгийн “Увс нам бус”, “МВС” телевизүүдтэй 7 хоног бүрийн Даваа гарагт эрүү хэв, журмын нөхцөл байдлыг, Баасан гарагт гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 66 удаа, давталт 96, нийт 288 минутын, ухуулга, яриа, сурталчилгааг иргэд олон нийтэд мэдээлэл хийсэн.

Тус цагдаагийн газраас “Сар шинэ-2019”, “Бяцхан зорчигч”, “Оюутан тээвэр”, “Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, “Байгалиа хамгаалья”, “Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, “Зөв тусгал” аян хүрээнд хийгдсэн “ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтэс” пэйж хаяганд байршуулсан шторк, постер, зурагт хуудсыг, мөн хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн видео бичлэг, контентуудыг “Увс аймаг дахь цагдаагийн газар” facebook хаяг, “Увс аймгийн нэгдсэн групп”, “Элхэн нутаг Увс”, “Увс миний нутаг”, “Бид увсынхан”, “Увс аймгийн зарын нэгдсэн групп” зэрэг 1125050 хандагчтай 21 цахим хуудсуудад тухай бүр байршуулсан, Маршал Ю.Цэдэнбалын талбайн урд талын лед дэлгэц, Цагдаагийн газрын урсдаг самбар, орон нутгийн “МВС”, “Увс нам бус”, “Увс” телевизүүдээр тус бүр сэрэмжлүүлэг мэдээ болон хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 1 шторк бэлтгэж иргэдэд олон нийтэд хүргэж ажилласан.

ЦЕГ-ын УСХ болон бусад албадаас ирүүлсэн нэгдсэн арга хэмжээ, тус цагдаагийн газраас зохион байгуулсан хэсэгчилсэн арга хэмжээ, сургалтын хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 28 төрлийн хууль, эрх зүйн гарын авлага, 38 төрлийн зөвлөмж, сэрэмжлүүлэг, 30 төрлийн зурагт хуудас, нийт 20715 ширхэгийг тараасан.

Тус аймгийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/103 тоот “Олон нийтийн эргүүл” ажиллуулах тухай захирамжыг гудамж талбайд үйлдэгдэх гэмт

хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллагын ажилтан, алба хаагч нарыг нийтийн эргүүлд 2019 оны 03 дугаар сарын 04-нээс 2019 оны 06 дугаар сарын 20-ны дотор зохион байгууллаа. Энэ хугацаанд 60 байгууллагын 250 ажилтан давхардсан тоогоор 450 байгууллага, аж ахуйн нэгжийн харуул манаа шалгаж, 28 хүнд хуулийн зөвлөгөө өгч, 4 төрлийн 350 ширхэг санамж, сэрэмжлүүлэг тарааж ажилласан.

Гудамж талбайд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд “Урамшуулалт эргүүл” хэсэгчилсэн арга хэмжээг 2019 оны 01 дүгээр сарын 15-наас 2019 оны 02 дугаар сарын 15-ныг хүртэлх хугацаанд сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохицуулах салбар зөвлөлүүдтэй хамтран зохион байгууллаа.

Арга хэмжээний хугацаанд хэсгийн төлөөлөгч, байцаагч нар хариуцсан сум, багтаа сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохицуулах салбар зөвлөлүүдээс 1390000/ нэг сая гурван зуун ерөн мянга/ төгрөгний урамшуулал шийдвэрлүүлэж давхардсан тоогоор 88 иргэнийг эргүүлд үүрэг гүйцэтгүүлэн урамшуулал олгож ажилласан.

Урамшуулалт эргүүлд ажилласан иргэд замын тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 99 тээврийн хэрэгсэл шалгаж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 7, эрхийн үнэмлэхгүй тээврийн хэрэгсэл жолоодсон 1 нийт 8 зөрчил илрүүлж, ААНБ-ын харуул манаа давхардсан тоогоор 86-г, согтууруулах ундаа худалдах зөвшөөрөлтэй 83 аж, ахуйн нэгжийг тус тус шалгаж, 1855 айл өрх, 159 аж ахуйн нэгжээр орж хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлдсэн 2 төрлийн 3710 ширхэг санамж сэрэмжлүүлгийг иргэд аж, ахуйн нэгж байгууллагуудад хүргэж ажилласан.

Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд тус цагдаагийн газар нь аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран 2019 оны 5 дугаар сарын 10-ны өдөр мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгарч байгаа асуудлыг шийдвэрлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, малчдын бүлэг нөхөрлөлийн гишүүдийн анхдугаар зөвлөгөөнийг” зохион байгуулж “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх ажил”, “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх онцлог ажлууд иргэдийн оролцоо сэдвээр”, “Иргэдийн эрх зүйн боловсролын талаар”, “Мал эмнэлгийн гэрчилгээний загвар, хэрэглэх заавар”, “Хилийн тухай хууль”, “Хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, урьдчилан сэргийлэх арга зам”, “Мал хулгайлах гэмт хэргийн талаар” гэсэн сэдвүүдээр тус тус сургалтыг хийлээ.

Тус зөвлөгөөнд хүрэлцэн ирсэн бүлэг нөхөрлөлийн гишүүдийг аймгийн музей үзүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвх зүтгэл гаргасан Цагаанхайрхан сумын 2-р багийн иргэн, Улаангом сумын 1-р багийн иргэн, 2-р багийн 3 иргэнийг Аймгийн хүндэт тэмдэгээр тус тус шагнаж урамшуулан ажиллалаа.

Тус аймгийн Давст, Бөхмөрөн, Наранбулаг, Хяргас, Цагаанхайрхан, Зүүнхангай, Малчин, Ховд, Зүүнговь, Сагил, Тариалан сумдын алба хаагчид “Нэг хором” аяны хүрээнд иргэдийн олон улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг угтаж баяр амралтын өдрийг “Архинаас татгалзъя, уураа тэвчье” уриан дор “Сагс”, “Гар бөмбөг”, “Мөсний тэмцээн”, “Уран жолоодлого-1,2”, “Буудлага-1,2”, “Дэвжээ”, “Масс мессеж”, “Хэн сайн дуулах вэ”, “Эмэгтэйчүүдийн чуулга уулзалт”, “Малчдын зөвлөгөөн” зэрэг арга хэмжээнүүдийг орон нутгийн удирдлагуудтай хамтран зохион байгуулж, төрийн байгууллагууд болон, сумдын ГХУСАЗСЗ-өөс 2140000 /хоёр сая нэг зуун дөчин мянга/ төгрөг шийдвэрлүүлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон 33 иргэнийг өргөмжлөл үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулсан.

Тус цагдаагийн газраас “Яараад яахавдээ” аяны хүрээнд үүрэн телофоны “Мобиком корпораци” ХХК-ний хэрэглэгчдэд: Мянган бээрийн аялал нэг алхамаас эхэлдэг. “Яараад яахав дээ” Увс Замын цагдаагийн тасаг, “Скайтел” ХХК-ний хэрэглэгчдэд: Зам тээврийн ослын улмаас жилд 500 гаруй хүн амь насаараа хохирч байна. Хурдаа тохируулж, хамгаалах бүсээ бүсэлье. “Яараад яахав дээ” Увс Замын цагдаагийн тасаг, “Юнител” ХХК-ний хэрэглэгчдэд: Аминаас үнэтэй цаг хугацаа гэж үгүй “Яараад яахав дээ” Увс Замын цагдаагийн тасаг” гэсэн бичигтэй зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх масс мессежийг аймгийн иргэдийн гар утсаар дамжуулж нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн болно.

Улсын баяр наадмын өдрүүдийг тохиолдуулан “Яараад яахав дээ” бичиглэл бүхий 10x15 см хэмжээтэй 200 ширхэг дарцаг хийж тээврийн хэрэгслүүдэд байршуулж ажилласан. “Хязгааргүй Дуулал” төрийн бус байгууллагуудын уран бүтээлчдийн тойрон аялал уран бүтээлийн тоглолт, Монгол улсын засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Хайртай” аяны хүрээнд “Хурд” хамтлаг тус аймагт ажиллах үеэр “Яараад яахав дээ” арга хэмжээг иргэдэд сурталчлах ажлыг хамтран зохион байгуулан ажилласан.

## 2.6. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын 2019 оны төлөвлөгөөнд “Замын хөдөлгөөний цагаан толгой 2019”, “Ногоон гэрэл цагаан шугам 2019”, “Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх өдөр”, “Зам тээврийн ослоор хохирсон иргэдэд хүндэтгэл үзүүлэх өдөр”, Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээ, мэдээлэл, шторк нэвтрүүлэх зардал, орон нутгийн болон улсын чанартай авто замуудад зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр самбар байрлуулах, сургууль орчим болон улсын чанартай авто замд “Хурдаа хас”, “Зогс хүүхэд” бичиглэл бүхий хэвтээ тэмдэглэл хийж гүйцэтгүүлэх санал оруулж, холбогдох хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлсэн.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах “Дэд зөвлөл”-ийг байгуулах саналыг хүргүүлж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/19 тоот тогтоолоор замын хөдөлгөөнийг аюулгүй байдлыг хангах “Дэд зөвлөл”-ийг 9-н хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Аймгийн Засаг даргын тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хуралтай хамтран “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын төлөө хамтдаа” зөвлөгөөнийг 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдөр цагдаагийн газрын дарга, замын цагдаагийн тасгийн дарга болон төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг оролцуулж зохион байгуулсан.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд Сургуулийн өмнөх насны хүүхдэд Замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, хөдөлгөөнд соёлтой оролцох дадлага эзэмшлүүлэх, тэднийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах “Замын хөдөлгөөний цагаан толгой-2019” тэмцээний зохион байгуулах удирдамж, зардалын тооцоог хүргүүлж, 1.300.000 төгрөгийг шийдвэрлүүлэн тэмцээнийг зохион байгуулсан.

Тээврийн цагдаагийн албанаас зохион байгуулж байгаа “Замын тэмдэг, тэмдэглэлийн бүрэн бүтэн байдал” хэсэгчилсэн арга хэмжээний дагуу аймгийн нутаг дэвсгэр дэх улсын болон орон нутгийн чанартай авто замын тэмдэг, тэмдэглэл, чиглүүлэх хэрэгсэл, туузан хашилт зэрэгт үзлэг, шалгалт, тооллого хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах, шаардлагатай тэмдэг, тэмдэглэлийн судалгаа гаргах ажлыг зохион байгуулах, цаашид авах арга хэмжээний талаар санал дүгнэлт гаргах АЗДТГ-ын

Хөрөнгө, оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэс, Цагдаагийн газар, аймгийн мэргэжлийн хяналтын газар, Улаангом сумын ЗДТГазар, Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГазар, Увс-АЗЗА ТӨХК-ийг албан тушаалтануудыг оролцуулсан “Ажлын хэсгийн бүрэлдэхүүн байгуулах тухай” аймгийн засаг даргын 2019.05.17-ны өдрийн А/308 тоот захирамж гаргуулан, хэрэгжилтийг хангаж дүнг аймгийн Засаг даргад танилцуулсан. Аймгийн ИТХ-ийн даргын 2019.06.25-ны өдрийн 150 дугаартай “Улсын чанартай авто замд самбар байрлуулах ажлыг “Увс АЗЗА” ТӨХК-нд чиглэл өгч ажиллаж байна. Тус аймгийн Бөхмөрөн, Тариалан, Сагил, Завхан, Өмнөговь, Баруунтуруун, Өлгий, Өмнөговь, Тэс сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс “Яараад яахав дээ” аяны хүрээнд орон нутгийн чанартай авто зам дагуу нөлөөллийн самбар хийхэд дэмжлэг үзүүлж нийт 18 ширхэг самбар хийж байрлуулсан.

Аймгийн Засаг дарга болон Улаангом сумын Засаг дарга, ИТХ-ын дарга нарт Улаангом сумын замын тэмдэг, тэмдэглэгээг сайжруулах, солих шаардлагатай, шинээр тавих тэмдгийн судалгааг хүргүүлсэн.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, аймгийн боловсрол соёл, урлагийн газартай хамтран Улаангом сумын ерөнхий боловсрол 6 сургууль, Улаангом коллежийн удирдлагуудтай 2019-2020 оны хичээлийн жилд зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулж ажилласан.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд 2020 онд зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулах ажил, арга хэмжээ, зарцуулагдах хөрөнгийн талаар танилцуулга хүргүүлсэн.

Тээврийн цагдаагийн албаны даргын 2019.01.16-ны өдрийн 14/124 тоот албан бичгээр ирүүлсэн ажлын чиглэлийн дагуу “Сар шинэ” нэгдсэн арга хэмжээг эрчимжүүлэх салбар төлөвлөгөө гарган зохион байгуулж ажилласан. Замын цагдаагийн газрын даргын 2019.01.30-ны өдрийн 14-2/81 албан бичгээр ирүүлсэн “техник, замын хяналт”-ийн чиглэлээр зохион байгуулах календарьчилсан төлөвлөгөөний дагуу хийж хэрэгжүүлэх ажлын салбар төлөвлөгөө гарган цагдаагийн газрын даргаар батлуулан ажиллаж байна. Цагдаагийн ерөнхий газрийн даргын 2019.01.31-ний өдрийн 5/662 тоот албан бичгийн дагуу Авто тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам, Замын цагдаагийн газрын даргын 2019.01.07-ны өдрийн 14-1/48 тоот албан бичгийн дагуу “Сар шинэ-2019” нэгдсэн арга хэмжээний салбар төлөвлөгөө гарган, үр дүнг тооцон ажилласан.

Тээврийн цагдаагийн албаны Техник замын хяналтын хэлтсийн даргын 2019.02.15-ны өдрийн 14-26/123 тоот албан бичгийн дагуу Аймгийн нутаг дэвсгэр дэх улсын чанартай авто зам, замын хэмжээ, теле камер, авто зогсоол, амрах талбайн судалгааг болон цаашид хийх шаардлагатай байгаа газруудын судалгааг загвар хүснэгтийн дагуу гаргаж хүргүүлсэн.

Тээврийн цагдаагийн албаны замын цагдаагийн газрын даргын 2019.03.03-ны өдрийн 14-2/168 тоот албан бичгээр ирүүлсэн “Урьдчилан сэргийлэх” календарьчилсан төлөвлөгөөний дагуу хийж хэрэгжүүлэх ажлын салбар төлөвлөгөө гарган цагдаагийн газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Замын цагдаагийн газрын даргын 2019.03.07-ны өдрийн 14-2/180 тоот албан бичгийн дагуу “Хурд” нэгдсэн арга хэмжээний салбар төлөвлөгөө гарган, үр дүнг тооцож биелэлтийг хүргүүлсэн.

Тээврийн цагдаагийн албаны даргаас ирүүлсэн 2019.03.11-ний өдрийн 14/526 тоот албан бичгийн дагуу иргэд, олон нийт, замын хөдөлгөөнд оролцогчдод хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль эрх зүйн мэдээллүүдийг сурталчилах, сэрэмжлүүлэх зорилгоор албаны байр, өрөө тасалгаа, хяналтын постуудад санамж



сэрэмжлүүлгийг зурагт хуудас, гарын авлага хэлбэрээр хийж иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулан ажилласан.

Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын даргын 2019.03.26-ны өдрийн 14-2/226 тоот албан бичгээр ирүүлсэн “Мэдээлэл хүргүүлэх тухай”, “Ачааны автомашины бүрэн бүтэн байдал, ачаа тээвэрлэлт”, 2019.04.30-ны өдөр 14-2/392 тоотойр ирүүлсэн “Замын тэмдэг, тэмдэглэлийн бүрэн бүтэн байдал” хэсэгчилсэн арга хэмжээг, 2019.04.16-ны өдрийн 14-2/308 тоот албан бичгээр ирүүлсэн “Мотоцикл” нэгдсэн арга хэмжээг, 2019.05.24-ны өдрийн 14-1/1204 тоот албан бичгээр ирүүлсэн “Бяцхан зорчигч” нэгдсэн арга хэмжээг аймгийн нутаг дэвсгэрт зохион байгуулан дүнг хүргүүлсэн.

Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2019.06.12-ны өдрийн 01/363 тоот албан бичгээр ирүүлсэн “Орон нутгийн зам хөдөлгөөний соёл” урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний дагуу хэрэгжүүлэх ажлын салбар төлөвлөгөө гарган Цагдаагийн газрын дарга, амгийн ГХУСАЗЗөвлөлийн даргаар батлуулан, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

ЦЕГ-ын УСХ-ийн даргын 2019.06.14-ний өдрийн 9/3385 тоот албан бичгээр ирүүлсэн төлөвлөгөөний дагуу “Яараад яахав дээ” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, танилцуулга, биелэлтийг хүргүүлсэн.

ТЦА-ны МШГ-ын даргын 2019.08.20-ний өдрийн 14-2/3740 тоот “Улсын дугаар-2019” НАХ-г явуулах, ТЦА-ны ЗЦГ-ын даргын 2019.09.06-ны өдрийн 14-2/832 тоот албан бичгээр ирүүлсэн “Тээврийн хэрэгслийн яндангаас гарах утаа, дуу, чимээ илэрхий зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тээврийн хэрэгсэлд тавих тээврийн хэрэгсэлт тавих хяналт” хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулах тухай албан бичгүүдийг хүлээн авч салбар төлөвлөгөө гарган биелэлт үр дүнг тооцож, танилцуулгыг Тээврийн цагдаагийн албанд хүргүүлсэн.

Цагдаагийн Ерөнхий газрын Тээврийн цагдаагийн алба, Урьдчилан сэргийлэх хэлтсээс улсын хэмжээнд зохион байгуулаж байгаа нэгдсэн арга хэмжээний хүрээнд улсын чанартай авто замын дагуу болон аймгийн нутаг дэвсгэрт хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийн жолооч нарын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрмийн хэрэгжилийг хангаж хөдөлгөөнд оролцож байгаа байдал, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хууль, дүрэм, стандар болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Орон нутгийн зам дахь авто замын хөдөлгөөн, хяналт шалгалт 1-2” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулсан.

Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын даргаас энэ оны 05 дугаар сарын 09-ний өдөр 14-2/434 тоотойр ирүүлсэн “Сонгодог автомашины уралдаанд оролцогч автомашин дамжин өнгөрөх үед зохицуулалт хийх” албан бичгийн дагуу хамгаалалт, зохицуулалтыг зохион байгуулж, танилцуулга, мэдээллийг хүргүүлсэн.

Аймгийн хүүхэд залуучууд, гэр бүлийн хөгжлийн газраас зохион байгуулсан “Хүүхдийг зодож шийтгэхгүй байх дэлхийн өдөр”, Ойрд театраас зохион байгуулсан “Дэлхийн бүжгийн өдөр”, аймгийн аварга шалгаруулах унадаг дугуйн тэмцээн, Улаангом, Өмнөговь, Цагаанхайрхан, Өлгий суманд зохион байгуулагдсан бүсийн болон хурдан морины бооцоот уралдаан, Монгол улсын тод манлай уяач Б.Далайгийн цолны мялаалга наадам, олон улсын хүүхдийн баяр, Аймгийн БТСГ-ны даргын 2019.06.26-ны өдрийн 1/112 дугаартай “Тамирчдын өдөр” арга хэмжээний үеэр хамгаалалт, зохицуулалт хийлгэх хүсэлтийн хүрээнд, сумдын ойн баяр, улсын баяр наадамд, аймгийн эрүүл мэндийн газраас зохион байгуулсан “Будагтай гүйлт”, Увс аймаг байгуулагдсаны 94 жилийн ой, үндэсний их баяр наадмын үеэр наадмын талбайд тээврийн хэрэгсэл чиглүүлэх, байрлуулах, хурдан морь барины газарлуу явах, буцах, морь барианы газарт тээврийн хэрэгслийг чиглүүлэх, байрлуулах схем зураглал, замын

хөдөлгөөний хамгаалалт, зохицуулалтанд ажиллах алба хаагч нарын томилгоог гаргаж Цагдаагийн газрын даргаар батлуулан замын хөдөлгөөний хамгаалалт зохицуулалтыг зохион байгуулсан.

Мөн Баян-өлгий аймгийн Ногоон нуур суманд тарваган тахал өвчин гарсантай холбогдуулан Ховд сумын Усан хоол нэртэй газар тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт, хорио цээрийн дэглэм тогтоож ажиллалаа.

Замын цагдаагийн албаны орон нутгийн хяналтын хэлтсийн дарга, нутаг дэвсгэр хариуцсан ахлах зохицуулагч, зохицуулагч нарт зам тээврийн осол болон замын хөдөлгөөний нөхцөл байдлын талаар тухай бүр танилцуулж, мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө авч ажилласан.

Тээврийн цагдаагийн албанаас зохион байгуулж байгаа “Орон нутгийн зам Хөдөлгөөний соёл 2019” нэгдсэн арга хэмжээний хүрээнд улсын болон орон нутгийн чанартай авто зам дайран өнгөрдөг Наранбулаг, Өндөрхангай, Зүүнхангай, Тариалан, Өлгий, Түргэн, Сагил, Давст сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарыг хөдөлгөөнт эргүүлд ажиллах хуваарь гарган ажиллуулж, үүрэг гүйцэтгэлтэнд тогтмол хяналт тавьж, удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллаж байна.

Улсын чанартай А-18 кодтой авто замын дагуу тус аймгийн Тариалан сумын нутаг дэвсгэрт байрлах замын цагдаагийн хяналтын постонд замын цагдаагийн 1, бусад тасаг, албадаас 1, нийт 2 алба хаагчийг 24 цагаар хуваарийн дагуу ажиллуулж байна. Мөн улсын чанартай А-18 кодтой авто замын дагуу аймгийн төвөөс 135 км Малчин сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах Хяргас нуурын “Хар тэрмэс”-ийн цагдаагийн постод замын цагдаагийн тасгийн 1 зохицуулагч, сумдын хэсгийн 1 алба хаагчийг, 1 автомашинтайгаар 10 хоногийн хугацаатай томилон ажиллуулж байна. Аймгийн төв Улаангом сумын уулзвар замуудад 25 байршилд 78 телекамер хэвийн ажиллагаатай ашиглагдаж байна.

Улсын чанартай А-18, А-1702 кодтой авто замууд болон Улаангом сумын “Хорооллын доторх” авто замуудад зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, тээврийн хэрэгслийн хурдыг тохируулаагүй, заагдсан хэмжээнээс хэтрүүлэх зөрчлийг илрүүлэх зорилгоор Тээврийн цагдаагийн албанаас тавьж олгосон хурд хэмжигч “Comlaser” багаж ашиглан Наранбулаг, Өндөрхангай, Зүүнхангай, сумын нутгаар дайран өнгөрч байгаа Улсын чанартай А-18 кодтой авто замд хяналт шалгалтыг хийж ажиллаж байна. Тайлангийн хугацаанд хурд хэтрүүлсэн 412 зөрчил илрүүлж бэлэн бус торгуулийн шалгах багжаар 16.480.000 төгрөгийн торгууль оногдуулж ажилласан.

Мөн олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулагдаагүй. Амралтын өдрүүдэд иргэдийн Увс нуур, Хяргас нуур, Үүрэг нуур, Хархираа, Цүнхэгийн амралтын чиглэлийн хөдөлгөөн нэмэгдэж байгаатай холбогдуулан улсын чанартай А-18, А-1702 кодтой авто замуудад 2 чиглэлд хөдөлгөөнт эргүүлийг ажиллуулсан

#### **а/ ЗХАБ-ын нөхцөл байдал, түүнд үндэслэсэн ажил, арга хэмжээ:**

Энэ оны эхний 3 дугаар улиралд албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын гэмт хэрэг, ослын 49 гомдол, мэдээлэл хүлээн авч, 13 гомдол, мэдээллийг харьяаллын дагуу мөрдөн байцаах тасагт шалгуулж, 36 осолд Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтаар арга хэмжээ тооцож шийдвэрлэсэн. Алба хаагчид гудамж замд хяналт шалгалт хийж ажиллах хугацаанд нийт 6598 зөрчил илрүүлснээс согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 337 зөрчилд зөрчлийн материал бүрдүүлэн шалгаж, 206 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг ЗТХ-иар 01 жилийн хугацаагаар хасаж, шийтгэлийн хуудсаар 82.400.000 төгрөгөөр торгож, эрхийн үнэмлэхгүй буюу эрх хасагдсан үедээ согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 131 иргэнийг сум дундын шүүхээр 7-30 хоногийн хугацаатай баривчлуулж, эрхийн

үнэмлэхгүй тээврийн хэрэгсэл жолоодсон 51 жолоочид шийтгэлийн хуудсаар 10.200.000 төгрөгөөр торгож, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн хүнд тээврийн хэрэгслийн жолоог шилжүүлсэн, бичиг баримтаа орхисон үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон, тээврийн хэрэгслийн хурд хэтрүүлсэн, хүн тээвэрлэх журам зөрчсөн, зам тэмдэглэлийн заалт зөрчсөн, хамгаалах бүс хэрэглээгүй, улсын үзлэг тооллогонд хамрагдаагүй зэрэг 26 зөрчилд зөрчлийн материал бүрдүүлэн шалган шийдвэрлэж, 157 тээврийн хэрэгслийг түр саатууж, Зөрчлийн тухай хууль тогтоомж зөрчсөн 10182 жолоочид бэлэн бус торгуулиар 311.538.000 төгрөгийн торгууль оногдуулж ажилласан.

Зорчих хэсгийн гадаргуу цасаар хучигдан халтиргаа гулгаа үүсч авто замын нөхцөл байдал хүндэрсэн үед мотоциклоор замын хөдөлгөөнд оролцогчдын эрүүл мэнд, осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, учирч болох хор хохирол, эрсдэлийг багасгах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт мотоцикльтойгоор замын хөдөлгөөнд оролцохыг 2018.11.05-ны өдрөөс 2019.04.15-ны өдөр хүртэлх хугацаанд хориглох тухай аймгийн Засаг даргын 2018.11.05-ны өдрийн А/708 тоот захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан.

Улаангом сумын нутаг дэвсгэрт болон улсын чанартай авто замын дагуу зам тээврийн осол, хэрэг гардаг цэгүүдэд замын цагдаагийн тасгийн алба хаагч нарыг болон зам дайран өнгөрдөг сумын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарыг ажиллуулж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр баригдах замын хөдөлгөөний хяналтын байнгын постын байршлыг тус аймгийн Түргэн сумын төвөөс 3 км зайд байрлах улсын чанартай А1702 кодтой авто замын дагуу N 50°07'23.8" E 091°42'01.4", N 50°07'23.9" E 091°42'02.6" координаттай газрыг сонгож газар эзэмших гэрчилгээ гаргуулахаар Түргэн сумын Засаг даргад, газар хөдлөлтийн бүсийг тогтоолгохоор Одон орон геофизикийн хүрээлэнд хүсэлтийг хүргүүлж хариуг авсан. Тухайн хяналтын постын ажлыг Ховд аймгийн "Богч" констаркшин ХХК хийж гүйцэтгэх ажлын тендэрт шалгарч хийж гүйцэтгэн барилгын ажлыг байнгын ашиглалатад өгөхөд бэлэн болоод байна.

Зам, замын байгууламжийг цэвэрлүүлэх, гэрлэн дохио хэвийн ажиллуулах талаар Хот тохижилт үйлчилгээний газар, "Увс АЗЗА" ТӨХК-д, хариуцсан байгууллагын зам талбайд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах ажилтан ажиллуулах Иргэний нисэх, Шинэ-Улаангом зах, Итгэлт худалдааны төв, Шөнийн захын удирдлагуудад, Улаангом сумын гэр хорооллын айл өрхийг дэд бүтэцд холбох ажил, арга хэмжээг хийж гүйцэтгэж байгаа 5 аж ахуйн нэгжид албан мэдэгдэл хүргүүлж биелэлтэнд хяналт тавьж ажилласан.

Аймгийн төвд авто сэлбэгийн худалдаа, засвар үйлчилгээ эрхэлдэг 10 аж ахуйн нэгжид зам тээврийн осол, зөрчилд холбогдсон тээврийн хэрэгслийн талаар мэдээлэл ирүүлж байх талаар албан мэдэгдэл хүргүүлсэн.

#### **б/ Урьдчилан сэргийлэх чиглэлээр:**

Авто тээврийн үндэсний төвийн захирал, Замын цагдаагийн газрын даргын хамтарсан "Сар шинэ-Тээвэрлэлтийн гэрээгүй зорчигч" нэгдсэн арга хэмжээг аймгийн нутаг дэвсгэрт зохион байгуулсан. Замын хөдөлгөөнд оролцож явсан жолооч нарт Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрмийн заалт, осол, хэргээс урьдчилан сэргийлсэн уриалга бүхий 1 төрлийн "Зөвлөмж" зурагт хуудас 150 ширхэгийг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах салбар зөвлөлтэй, Замын хөдөлгөөний дүрмийн зарим заалт, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, хөдөлгөөнд соёлтой оролцохыг уриалсан, анхааруулга бүхий 2 төрлийн 300 ширхэг зурагт хуудас, гарын авлагыг тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх сургалт явуулдаг Цагдаагийн газрын "Ахмадын холбоо"-той хамтран эх хувийг бэлтгэн, хэвлэн тараасан.

Аймгийн төвд тээврийн хэрэгслийн хөдөлгөөн төвлөрдөг аж ахуйн нэгжүүдэд хөдөлмөр аюулгүй байдлын ажилтан ажиллуулах, осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр болон нийтийн тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг 2 аж ахуйн нэгжид тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдлыг хангуулах талаар албан мэдэгдэл хүргүүлж биелэлтийг тооцсон.

Тээврийн цагдаагийн албанаас улсын хэмжээнд зохион байгуулаж байгаа “Сар шинэ 2019” нэгдсэн арга хэмжээний хүрээнд улсын чанартай А-1702 дугаартай авто замын дагуу болон Түргэн, Сагил, Давст дэвсгэрт хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийн жолооч нарын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрмийн хэрэгжилтийг хангаж хөдөлгөөнд оролцож байгаа байдал, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хууль, дүрэм, стандарт болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор замын цагдаагийн тасгийн зохицуулагч 2, цагдаа зохицуулагч 1, нийт 3 алба хаагч 1 автомашинтайгаар 2019.01.28-ны өдөр “Орон нутгийн зам дахь авто замын хөдөлгөөн, хяналт шалгалт 2” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулсан.

Арга хэмжээний хүрээнд зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйл, заалтаар 2 төрлийн 500 ширхэг санамж хэвлэн тараасан. Мөн хүүхдүүдээ зам хөндлөн гарахдаа баримтлах 3 дүрмийг мөрдөцгөөе” бичигтэй 200 ширхэг зурагт хуудас бэлтгэж бага насны хүүхдүүд болон эцэг эх, харгалзан дэмжигч нарт тараасан.

Увс аймгийн нутаг дэвсгэрт цас орж Улаангом сумын доторх болон улсын чанартай хатуу хучилттай уулзвар, авто замын зорчих хэсэгт халтиргаа, гулгаа үүсэж зам тээврийн осол, хэрэг гарч болзошгүй тул автозам, засвар хариуцсан байгууллага аймгийн АЗЗА ТӨХХ, Улаангом сумын Хот тохижилтын газарт гудамж замд үүссэн халтиргаа, гулгааг арилгах талаар албан мэдэгдэл хүргүүлж, үр дүнг тооцсон.

Тээврийн цагдаагийн албаны даргын баталсан календарчилсан төлөвлөгөөний хүрээнд “Тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэх хэрэгсэл” нэгдсэн арга хэмжээний салбар төлөвлөгөө гарган Увс аймгийн нутаг дэвсгэрт уг арга хэмжээг зохион байгуулсан.

Улсын чанартай А18, А1702 кодтой авто замаар замын хөдөлгөөнд оролцсон тээврийн хэрэгслүүдийн хурдыг хэмжиж, тогтмол хяналт хийж ажиллаж байна.

Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран аймгийн Эрүүл мэндийн газар, Авто тээврийн төв, Мэргэжлийн хяналтын газар, Түмэнд нээлттэй хязгаарынхан ХХК, Ач Буян Трэйвел ХХК, Хот тохижилт үйлчилгээний газар, “Увс АЗЗА” ТӨХК-ны алба хаагчдын оролцоотойгоор Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах сэдэвт зөвлөгөөнийг зохион байгуулсан.

“Ачааны автомашины бүрэн бүтэн байдал, ачаа тээвэрлэлт” нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу салбар төлөвлөгөө гарган, сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарт хүргүүлэн зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд аймгийн “Онцгой байдлын газар”, “Хилийн цэргийн 0245 дугаар анги”, “Увс АЗЗА” ТӨХК, Ундарга Увс ХХК, “Ник петровис” ХХК, “Тэс петролиум” ХХК, “Түмэнд нээлттэй хязгаарынхан” ХХК, Улаангом сумын “Хот тохижилтын газар”, “Чандмань уулын жинчид” хоршооны ачааны автомашинуудад үзлэг хийж, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, иж бүрдэл, жолоочийн бичиг баримтанд шалгалт хийж, илэрсэн зөрчилд хууль зүйн зөвөлгөө өгч ажилласан.

Аймгийн Засаг даргын 2019.04.11-ний өдрийн А/191 тоот захирамжын хэрэгжилтийг хангах, “Ачааны автомашины бүрэн бүтэн байдал, ачаа тээвэрлэлт” нэгдсэн арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор Увс АЗЗА ТӨХК, Автотээврийн төв, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газрын алба хаагчидтай хамтран улсын

болон орон нутгийн чанартай авто замд хяналт шалгалт хийж, ачааны тээврийн хэрэгслүүдийг пүүгээр хэмжиж, нийт 8 зөрчил илрүүлж мэргэжлийн хяналтын газарт шилжүүлж хариуцлага тооцуулсан.

Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын даргын 2019.04.16-ны өдрийн 14-2/308 тоот албан бичгээр ирүүлсэн “Мотоцикл” нэгдсэн арга хэмжээний хүрээнд сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын болон алба хаагч нарын хийсэн ажлын мэдээг өдөр бүр нэгтгэж Тээврийн цагдаагийн албаны Шуурхай удирдлагын албанд өгч ажилласан. Мөн аймгийн төвд мотоцикл худалдаалдаг иргэн, аж ахуйн нэгжийн судалгааг гаргаж, мотоцикл худалдаалахдаа улсын дугаар, зориулалтын хамгаалах малгай дагалдуулж худалдах талаар албан мэдэгдэл өгч ажилласан.

“Нэг хором хүлээ” аяны хүрээнд Увс аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгаас 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 10.00-12.00 цаг хүртэл Улаангом сумын 3-р багийн нутаг дэвсгэрт байрлах “Бэл булаг” худалдааны төвийн урд талбайд “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг зохион байгуулсан. Арга хэмжээнд хамтран ажилладаг аймгийн Татварын хэлтэс, аймгийн авто тээврийн төв, жолооч бэлтгэх автокурсуудийн холбооны ажилтан, алба хаагч, төлөөллийг оролцуулж, хариуцсан ажлын чиглэлээр иргэдэд мэдээ, мэдээлэл хийлгэж, зөвлөмж, гарын авалга тараасан. Замын цагдаагийн тасгийн 9 алба хаагч уг арга хэмжээнд ажиллаж “1 хором хүлээ” бичиглэл бүхий зурагт наалтыг 20 тээврийн хэрэгслийн хаалган дээр байрлуулсан. Замын хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрмийн холбогдох заалтаар болон жолоодох эрх сэргээлэх, жолооны үнэмлэх нөхөн авахад бүрдүүлэх материалын талаар 5 төрлийн 220 ширхэг санамж, зөвлөмж, гарын авлага бэлтгэн иргэд, жолооч нарт тараасан.

Тээврийн цагдаагийн албанаас 2019 онд зохион байгуулах “Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний календарчилсан төлөвлөгөө”-ний хуваарийн дагуу Тээврийн цагдаагийн албаны даргын 2019.01.16-ны өдрийн 14/124 тоот албан бичгээр ирүүлсэн ажлын чиглэлийн дагуу “Сар шинэ”, “Хурд”. “Ачааны автомашины бүрэн бүтэн байдал, ачаа тээвэрлэлт”, “Замын тэмдэг, тэмдэглэлийн бүрэн бүтэн байдал” “Мотоцикл” “Бяцхан зорчигч”, “Яараад яахав дээ” “Улсын дугаар-2019” “Тээврийн хэрэгслийн яндангаас гарах утаа, дуу, чимээ илэрхий зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тээврийн хэрэгсэлд тавих тээврийн хэрэгсэлт тавих хяналт”, “Оюутан тээвэр” “Замын тэмдэг, тэмдэглэлийн бүрэн бүтэн байдал” хэсэгчилсэн арга хэмжээ, “Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл 2019”, “Мотоцикл”, “Улсын дугаар”, “Хичээлийн шинэ жил” нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулах салбар төлөвлөгөө гарган зохион байгуулж, үр дүнг тооцсон.

Аймгийн авто тээврийн төвөөс зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээнд оролцож, нийтийн тээврийн хэрэгслийн жолооч нарт болон авто тээврийн төвөөр үйлчлүүлж байгаа иргэдэд Замын хөдөлгөөний дүрэм, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, мэдээ зохион байгуулсан.

Хилийн цэргийн 0245-р ангийн 2019 оны 1-р ээлжийн цэрэг тээвэрлэлтэнд явах “Винчин” маркийн 1195ХЦА улсын дугаартай автомашин, “Камаз” маркийн 1661 ХЦА улсын дугаартай автомашин, “Зил-130” маркийн 1988 ЦАБ автомашинуудын техникийн бүрэн бүтэн байдал, иж бүрдэл, 3 жолоочийн албан томилолт, жолоочийн жолоодох эрхийн үнэмлэх тухайн тээврийн хэрэгсэл жолоодох ангилалд тохирч байгаа эсэх, хүчинтэй эсэхийг цагдаагийн шалгах багажаар шалгаж, цэрэг тээвэрлэлтэнд явах жолооч нарыг замын хөдөлгөөнд оролцохоос өмнө согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг согтуурал шалгах багажаар шалгаж, цэрэг тээвэрлэлтэнд явж байгаа тээврийн

хэрэгслийн жолооч болон ахлагч нарт зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлж, аюулгүй байдлаа хангах, улсын болон орон нутгийн чанартай замд тээврийн хэрэгслийн хурдыг тогтоосон хязгаараас хэтрүүлэхгүйгээр сонгож явах, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, замын хөдөлгөөний дүрмийг баримтлаж хөдөлгөөнд оролцох талаар зааварчилга, зөвлөмж өгч ажилласан.

Сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн дунд 2019 оны 04-р сарын 26-ны өдөр “Замын хөдөлгөөний цагаан толгой 2019” тэмцээнийг зохион байгуулсан. Тэмцээнд Улаангом сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг нийт 10 цэцэрлэгийн баг тамирчид оролцсоноос тэргүүн байранд 1-р цэцэрлэгийн “Жавхаа” баг, хоёрдугаар байранд 2-р цэцэрлэгийн “Гарц” баг, гуравдугаар байранд 8-р цэцэрлэгийн “Сүлд” баг тус тус шалгарсан.

Аймгийн жолооч бэлтгэх эрх бүхий автокурсын захирлуудад 2019 оны А/46, А/09 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалт авах журам”, Хөдөлмөрийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны А/171, А/496 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор бичгээр зөвлөмж өгсөн.

“Орон нутгийн зам хөдөлгөөний соёл” урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний дагуу хэрэгжүүлэх ажлын салбар төлөвлөгөө гарган Цагдаагийн газрын дарга, аймгийн ГХУСАЗЗөвлөлийн даргаар батлуулан, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Арга хэмжээний хүрээнд Цагдаагийн газрын удирдлага, аймгийн ЗДТГ-ын хууль зүйн хэлтэс, аймгийн мэргэжлийн хяналтын газар, аймгийн онцгой байдлын газрын ажилтан алба хаагч нарыг оролцуулсан хэвлэлийн бага хурлын зохион байгуулсан. Улсын болон орон нутгийн чанартай авто зам дайран өнгөрдөг Наранбулаг, Өмнөговь, Тариалан, Өлгий, Түргэн, Сагил, Давст сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа, олон нийтийн байцаагч нарыг хөдөлгөөнт эргүүлд ажиллах хуваарь гарган ажиллуулж, үүрэг гүйцэтгэлтэнд тогтмол хяналт тавьж, удирдалга, зохион байгуулалтаар ханган ажиллаж байна.

“Бяцхан зорчигч” нэгдсэн арга хэмжээний хүрээнд олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр “Хүүхдийг эрхийг хамгаалъя” автомашингүй өдөр арга хэмжээг зохион байгуулж, 450 хүүхдийг хамруулан, “Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлцгээе”, “Жолооч нараа тээврийн хэрэгслийн хурдыг тохируулж замын хөдөлгөөнд соёлтой оролцсноор гарч болзошгүй осол, хэргээс урьдчилан сэргийлнэ”, “Та хурд 1 км/ц хасахад гарах эрсдэлийг 4-5% бууруулна”, “Хурдаа хасаж ирээдүйгээ гэрэлтүүлцгээе”, “Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохыг таслан зогсооё”, “Бид монголын ирээдүй”, “Жолооч ахаа та хурдаа тохируулаарай”, “Өнөөдрийн таны хийсэн үйлдэл маргаашийн миний ирээдүй” бичиглэл бүхий уриалга бариулан замаар алхуулах жагсаал зохион байгуулсан.

“Оюутан тээвэр” нэгдсэн арга хэмжээний хүрээнд нийтийн тээвэрийн үйлчилгээ эрхэлдэг “Түмэнд нээлттэй хязгаарынхан” ХХК, “Ач буян трейвэл” ХХК-иар үйлчлүүлж буй зорчигчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор зам маршрутад өдөр бүр хяналт шалгалтыг хийж ажилласан.

Зохион байгуулсан арга хэмжээний хүрээнд “Орон нутгийн зам хөдөлгөөний соёл”, “Бяцхан зорчигч”, “Хүүхдийг зөв зорчуулья”, “Сонс, хар, зогс”, “Хүүхдийн зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлцгээе”, “Эцэг эхчүүдээ бага насны хүүхдээ зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж зориулалтын суудлыг хэрэглэж хэвшицгээе” гарын авалга, зөвлөмж иргэд, жолооч нарт тараасан.

Зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтийг хангах, иргэд олон нийтэд сурталчилах, замын цагдаагийн тасгаас зохион байгуулж, авч хэрэгжүүлж байгаа

арга хэмжээний талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 34 удаа мэдээлэл хийж, Увс аймаг дахь Цагдаагийн газар, Тээврийн цагдаагийн албаны “Орон нутгийн замын цагдаа”, Facebook, сайтуудад 83 удаа мэдээ, мэдээлэл байршуулж ажилласан.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон жолоочийн албан байгууллага, харьяалагдах багийн Засаг дарга нарт зөрчлийг арилгуулах, урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулахыг даалгасан албан шаардлага 215-г хүргүүлж, зөрлийг арилгуулах ажлыг зохион байгуулсан.

“Орон нутгийн зам хөдөлгөөний соёл” нэгдсэн арга хэмжээний хүрээнд аюул ослоос урьдчилан сэргийлэх “Зурагт зөвлөмж”, “Яараад яахав дээ” бичигтэй 2 төрлийн нийт 1000 ширхэг санамж, сэрэмжлүүлэг, яараад яахав дээ дарцгийг баяр наадмын өдрүүдээр 500 ширхэг, улсын чанартай А-1702 кодтой авто замд Оросын холбооны улсын Тува улсын иргэд ихээр зорчдог тул “Та хурдаа тохируул”, “Та бүсээ бүслээрэй” гэсэн үгийг Орос хэл дээр орчуулсан 2\*2,5м харьцаатай зурагт самбар, Улсын чанартай А-18 кодтой авто замд “Яараад яахав дээ”, “Та амьдралын жолоог атгаж явна” гэсэн бичиглэлтэй 2х3м харьцаатай зурагт самбарыг байрлуулсан. Увс аймагт үйл ажиллагаа явуулдаг “Юнител”, “Мобиком”, “Жи мобайл”, “Скайтел” ХХК-тай хамтран санамж, сэрэмжлүүлэг хэлбэртэй масс мессэжийг Увс аймгийн иргэдэд хүргүүлсэн.

“Яараад яахав дээ” аяны хүрээнд нөлөөллийн самбар байрлуулах талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хүсэлт хүргүүлж нийт 24 ширхэг самбар байрлуулсан. Нийтийн тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг “Түмэнд нээлттэй хязгаарынхан” ХХК, “Ач буян трейвэл” ХХК-ний автобусны лед дэлгэцээр аяны хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн пэйж хуудсанд байршуулсан зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр олны танил хүмүүсийн уриалсан богино хэмжээний 4 төрлийн шторкыг иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулсан.

“Мотоцикл” нэгдсэн арга хэмжээний хүрээнд мотоцикл худалдаалахдаа стандарт шаардлага хангасан хамгаалах малгай дагалдуулж байх талаар 4 ажил ахуйн нэгжид албан мэдэгдэл хүргүүлсэн.

Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр Улаангом коллеж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн удирдлагуудтай 2019-2020 оны хичээлийн жилд хамтран ажиллах гэрээг байгуулан ажилласан.

### **в/ Зам зохион байгуулалтын чиглэлээр:**

Улаангом сумын 7 дугаар багийн нутагт байрлах “Ундарга-Увс”-ийн 3-н замын уулзварт Центр хаусын 3-н замын уулзварт туршилтын журмаар 3 ш теле камер суурьлуулсан. Улаангом сумын 6 дугаар багийн нутаг арын 4-н замын гэрлэн дохио, Улаангом сумын 3 дугаар багийн нутагт Цас дэлгүүрийн 4-н замын уулзваруудын гэрлэн дохио ажиллахгүй байх тул энэ талаар холбогдох байгууллагад албан мэдэгдэл хүргүүлж хэвийн ажиллуулсан.

Улаангом сумын хот тохижилтын газартай хамтран гудамж замын гэрэлтүүлгийн эвдрэл гэмтэлд үзлэг, шалгалт хийхэд авто зам дагуух нийт 1297 гэрэлтүүлгийн нийт асалт 91%-тай байна.

Аймгийн “УВС АЗЗА” ТӨХК-ны мэргэжилтэн, “Мэргэжлийн хяналтын газар”, Авто тээврийн үндэсний төвийн улсын байцаагч нартай хамтран 3 удаа улсын чанартай А-18, А-1702 кодтой автозамуудад зам тээврийн осол, хэрэг, замын эвдрэл гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор зөөврийн пүү ашиглан хяналт шалгалтыг зохион байгуулсан. Увс АЗЗА” ТӨХК орон нутгийн чанартай Улаангом-Ховд чиглэлийн А1701 кодтой авто замын 1-ээс 15 км хүртлэх замын зурваст цэвэрлэгээ хийсэн.

Улаангом сумын засаг даргад 2019.04.19-ний өдөр 48/613 тоот албан бичгээр Улаангом сумын доторх авто замд тавигдсан зарим тэмдэг, тэмдэглэгээ муудаж,

бүдгэрч арилсан, хөдөлгөөнд оролцогчдод ойлгомжгүй MNS4596:2014 “Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм” МУ-ын стандарт шаардлага хангахгүй байгаа тул ажлын хэсэг гаргаж тэмдэг, тэмдэглэгээг тоолох, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар албан тоот хүргүүлсэн.

Улаангом сумын нутаг дэвсгэрт байрлах, улсын болон орон нутгийн чанартай авто замуудад байрлах замын тэмдгүүдэд засварын ажил хийгдээгүй. “Увс АЗЗА” ТӨХК-р Улаангом-Хандгайт чиглэлийн А1702 кодтой улсын чанартай авто замын 0-14 км-ийн хоорондох замын хамгаалалтын бетон шон буюу түмбэ, бетон гүүр, хайс хайшлагыг будах ажлыг хийлгэж байгаа бөгөөд түмбэнүүдийг будах ажлын гүйцэтгэл 50 хувьтай, бетон гүүр, хайс хайшлагыг будах ажлын гүйцэтгэл 90 хувьтай явагдаж байна.

Улаангом сумын хот тохижилт, үйлчилгээний газрын алба хаагчдаар Улаангом сумын нутаг дэвсгэрт байрлах хатуу хучилттай төв замд өдөр бүр өглөө 06 цагаас 07 цаг 30 минут хүртэл 13тн ус цацуулж замын бохирдол, тоосжилтыг арилгуулж ажилласан.

“Замын тэмдэг, тэмдэглэлийн бүрэн бүтэн байдал” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд аймгийн засаг даргын захирамжийн дагуу ажлын хэсгийн бүрэлдэхүүн аймгийн төв болон улсын чанартай Улаангом-Үүрэг, Цагаан нуурын чиглэлийн А-16 кодтой авто замын, Улаангом-Ховд аймаг чиглэлийн А-1701, Улаангом-Хандгайд чиглэлийн А-1702, Улаангом-Наранбулаг-Завхан аймгийн Сонгино сумын чиглэлийн 4-18 кодтой авто замын дагуу тавигдсан тэмдэг, тэмдэглэл, чиглүүлэх хэрэгсэл, туузан хашил нь зохих дүрэм, стандарт шаардлагад нийцэж байгаа эсэхэд үзлэг шалгалтыг хийж 1218 босоо тэмдэг, шинэчлэх шаардлагатай 176 ширхэг тэмдэг, мэдээлэх самбар 12, шинэчлэх шаардлагатай 3, ган туузан хашлага 10 метр урт, шинээр хийх тэмдэг 622, мэдээлэх самбар 5, ган туузан хашлага 2400 метр урд шаардалгай гэсэн судалгааг гаргасан. Аймгийн төвийн гудамж замын тэмдэг, тэмдэглэгээнд үзлэг, шалгалт хийхэд одоо байгаа тэмдэг 415, солих шаардлагатай 35, засварлах шаардлагатай 17, шинээр тавих шаардлагатай 128, явган хүний гарц 10, стандарт шаардлага хангахгүй буулгах шаардлагатай 83 тэмдэгийн судалгааг гаргасан. Мөн бүдгэрч арилсан явган хүний гарцийн 44 байршилд 1265 метр<sup>2</sup> газрыг тэмдэглэлийг тодлох, зогс цагаан шугамтай болгох, 29 км замын үргэжилсэн болон тасархай цагаан шугамыг тодлох шаардлагатай гэсэн судалгааг гаргаж аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлсэн.

Зам тээврийн хөгжлийн яам, Авто замын хөгжлийн газар, Тээврийн цагдаагийн албаны мэргэжилтнүүдтэй хамтран улсын чанартай А1702, А18 кодтой авто замуудад үзлэг шалгалт хийж 362 ширхэг босоо тэмдэг, жолоочийн амрах зогсоол 1 ширхэг байгуулахаар шийдвэрлэсэн ба уг ажлыг “Увс АЗЗА” ТӨХК хийж гүйцэтгэхээр бэлтгэж ажлаа хангаж байна. Зам болон замын хөвөө, гүүр, ус зайлуулах хоолойн эвдрэлийн судалгааг гаргаж, засуулах, замын хөвөөг стандарт шаардлагын дагуу хийлгэх, борооны ус зайлуулах хоолойг цэвэрлэх, хоолой орчмын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар “Увс-АЗЗА ТӨХК”-нд албан мэдэгдэл хүргүүлсэн. Улсын чанартай А18 кодтой авто замд 1466 ширхэг тумба будах, шинээр 84 ширхэг босоо тэмдэг байрлуулах, Улаангемоос 18 км зайнд байрлах “Тээлийн гүүр”-ний дамжих хавтан засварлах, А-1702 кодтой авто замын 1113 ширхэг тумба будах, шинээр 148 ширхэг замын босоо тэмдэг байрлуулах, 4 гүүрний дамжих хавтан засварлах, 1 ус зайлуулах хоолойны 12 куб метр шороо зайлуулах судалгааг гарган “Увс-АЗЗА ТӨХК” хийж гүйцэтгэж байна.

Аймгийн төвд байрлалтай Гашууны голын гүүрний баганад гэмтэл учирсантай холбогдуулан уг гүүрийг засварлаж хэвийн ажиллагаанд орох хүртэл уг гүүрээр 12 тн-оос дээш жинтэй тээврийн хэрэгслийг орохыг хориглосон тэмдэг 2ш, чигийн заах тэмдэг 2 ширхэг тавигдсан.



Улаангом сумын нутаг дэвсгэрт авто зам дагуу нийт 26 цэгт 78 теле камертай бөгөөд Онцгой байдлын 4-н замын уулзварын 4, Арын 4-н замын уулзварын 3, Улаан уулын 1, нийт 8 ширхэг камерт засвар, үйлчилгээ хийж хэвийн ажиллагаанд оруулсан. Нийт 76 камер хэвийн ажиллаж байна. Улаангом сумын нутаг дэвсгэрт байрлах гэрлэн дохионд засвар үйлчилгээ хийгдээгүй. Аймгийн төвд нийт 7 уулзварт байгаа гэрлэн дохио хэвийн ажиллаж байна.

Зам тээврийн хөгжлийн яам, Авто замын хөгжлийн газар, Тээврийн цагдагийн албаны мэргэжилтэнгүүдтэй хамтран улсын чанартай А1702, А18 кодтой авто замуудад үзлэг шалгалт хийж 362 ширхэг босоо тэмдэг, жолоочийн амрах зогсоол 1 ширхэг байгуулахаар шийдвэрлэсэн ба уг ажлыг Увс АЗЗА ТӨХК-р хийж байгаа тул гүйцэтгэлтэнд хяналт тавин ажиллаж байна.

Увс АЗЗА ТӨХК-р Улаангом-Хандгайт чиглэлийн А1702 кодтой улсын чанартай авто замын 0-14 км-ийн хоорондох замын хамгаалалтын бетон шон буюу түмбэ, бетон гүүр, хайс хайшлагыг будах ажлыг хийлгэж байгаа бөгөөд түмбэнүүдийг будах ажлын гүйцэтгэл 50 хувьтай, бетон гүүр, хайс хайшлагыг будах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Улаангом сумын хот тохижилт үйлчилгээний газрын алба хаагчдаар Улаангом сумын нутаг дэвсгэрт байрлах хатуу хучилттай төв замд өдөр бүр өглөө 06 цагаас 07 цаг 30 минут хүртэл 13тн ус цацуулж замын бохирдол, тоосжилтыг арилгуулж ажилласан.

Улаангом-Хандгайт чиглэлийн А1702 кодтой улсын чанартай авто замд 1113ш түмбэ будаж сэргээсэн, төмөр бетон гүүрүүдийн хайс, дугуй цохигч будаж сэргээсэн. Үүрэг, Цагааннуур чиглэлийн А16 кодтой авто замд 150ш түмбэ, 144 метр төмөр бетон гүүрийн хайс, дугуй цохигч будаж сэргээсэн

Өмнөговь сумын Намир багт шинээр авто зам дагуу анхааруулах болон мэдээлэх 16 ширхэг тэмдэг шинээр тавигдсан. Улаангом сумын 7 дугаар багийн нутагт байрлах Цогцолбор 1 дүгээр сургуулийн бүсэд авто зам дагуу 300 метр ган туузан төмөр хашлагыг аймгийн ИТХ-аас санхүүжүүлэн 30.0000 төгрөгийн санхүүжилтээр УВС-АЗЗА ТӨХК хийж гүйцэтгэсэн.

Аймгийн төвд нийт 7 уулзварт байгаа гэрлэн дохио хэвийн ажиллаж байна. Улаангом сумын 1 дүгээр багийн нутагт шинээр тавигдаж буй 2,8 км урттай хатуу хучилттай авто замын хяналтанд 1 удаа ажилласан.

Улаангом сумын хот тохижилт үйлчилгээний газраас аймгийн төвийн авто замын цэвэрлэгээ үйлчилгээг 3 удаа зохион байгуулсан. Улаангом сумын 4 дүгээр баг, 5 дугаар баг 11 дүгээр багуудын нутаг дэвсгэрт байрлах авто замуудын 136м<sup>2</sup> замыг нөхөх ажлын гүйцэтгэлд нь 2 удаа, Увс АЗЗА ТӨК-ний харицдаг улсын чанартай А-1702 кодтой авто замын 2000 м<sup>2</sup>, 1701 кодтой авто замын 255 м<sup>2</sup> замын эвдрэлийн нөхөөс тавих ажлын хяналтанд 1 удаа тус тус ажилласан.

Өмнөговь сумын нутагт байх Намирын голын 48,8 метр урттай төмөр бетон гүүр, шинээр баригдсан 1,2 метр урттай бетон автозам, сайжруулсан 5,3 км урттай хайрган замыг хүлээн улсын комисст 1 удаа ажилласан.

Улаангом сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг ерөнхий боловсролын 6 сургууль орчмын замын тэмдэг тэмдэглэгээнд “MNS6444:2014 сургуулийн орчмын бүс” Монгол Улсын стандарт шаардлагыг хангаж байгаа эсэхэд үзлэг шалгалт хийж 6 цэгт анхааруулах 12 ш , мэдээлэх 12 ш тэмдэг байрлуулах, элэгдэж муудаж тахийсэн, бүдгэрч арилсан тэмдэглэгээг засаж хэвийн байдалд оруулах талаар Улаангом сумын Хот тохижилт үйлчилгээний газар албан мэдэгдэл хүргүүлээд байна.

Улаангом талаас 6км-т Улсын чанартай А-1702 кодтой авто замд Мэдээллийн 7.5м<sup>2</sup> хэмжээтэй самбарын бичлэгийг засаж сэргээх. Улаангом талаас 6км-т Улсын чанартай А-18 кодтой авто замд 288м<sup>3</sup> хэмжээтэй Зөөврөөр даланг УВС-АЗЗА ТӨК хийж гүйцэтгэж байна. /зогсоол хийв./

Улаангом сумын нутаг дэвсгэрт авто зам дагуу нийт 26 цэгт 76 теле камертай бөгөөд Онцгой байдлын 4-н замын уулзварын 4, Арын 4-н замын уулзварын 3 ширхэг камерт засвар, үйлчилгээ хийж хэвийн ажиллагаанд оруулсан. Нийт 74 камер хэвийн ажиллаж байна.

Улаангом сумын нутагт 38 байршид авто замын эвдрэлийг засаж янзлах, албан мэдэгдэл хүргүүлснээр Улаангом сумын нутаг дэвсгэрт байрлах авто замуудын 285м2 замыг нөхөх ажлыг Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮ газар нэмж хийж гүйцэтгэсэн.

#### **г/ Техник, хяналтын чиглэлээр:**

2019 онд төв, орон нутгийн хэмжээнд техник замын хяналтын чиглэлээр тээврийн хэрэгсэл, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих ажлын нэгдсэн хуваарийн “Тээврийн хэрэгслийн гэрэлтүүлэх хэрэгсэл”, “Тусгай дуут гэрэл, дохио”, “Тээврийн хэрэгслийн яндангаас гарах утаа, дуу чимээ илэрхий зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тээврийн хэрэгсэлд тавих хяналт”, “Улсын дугаар” сэдэвт нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулах салбар төлөвлөгөө гарган зохион байгуулж, биелэлт үр дүнг тооцож ажилласан.

Аймгийн Автотээврийн төвийн даргад 2019 оны тээврийн хэрэгслийн техник үзлэг, оношлогоо ажил, арга хэмжээ явагдаж байгаатай холбогдуулан аймгийн нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа автотээврийн хэрэгслийн техникийн байдал, хэрэглээний стандартын үзүүлэлтийг хангуулах, авто тээврийн хэрэгслээс хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг үр дагаврыг бууруулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор техникийн стандарт, шаардлага хангаагүй авто тээврийн хэрэгсэлд болон автотээврийн хэрэгслийг үзлэгт хамруулахгүйгээр техникийн хяналтын үзлэгт тэнцүүлсэн дүгнэлт гаргахгүй байх талаар албан мэдэгдэл хүргүүлсэн.

Гудамж замын хяналт шалгалтаар хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслүүдэд хяналт шалгалт зохион байгуулан ажиллаж Зөрчлийн тухай хуулийн 14.7.10.2 дугаар заалтаар 418 жолоочийг 20.900.000 төгрөгний торгууль оногдуулж, 26 жолоочийн зөрчлийг газар дээр нь засуулж ажилласан.

Улсын бүртгэлийн дугаар нь бүдгэрч, арилсан бүдгэрч үзэгдэх байдал нь муудсан тээврийн хэрэгсэл жолоодсон 1186 зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 14.7.11.1, 14.7.11.2, 14.7.11.3 дахь заалтуудаар 11.860.000 төгрөгийн торгууль оногдуулж, 86 жолоочийн зөрчлийг газар дээр нь арилгуулж ажилласан.

Зөрчлийн тухай хуулийн 14.7.15 заалтаар 2727 зөрчилд 54.540.000 төгрөгний, мөн хуулийн 14.7.14 дэхь заалтаар 58 зөрчилд 5.500.000 төгрөгний бэлэн бус торгууль оногдуулж ажилласан.

#### *Гурав. Дүгнэлт*

Тус цагдаагийн газар нь урд оны эрүү, хэв журмын нөхцөл байдал, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийж, эргүүлийн хуваарь, маршрутыг оновчтой болгож, морт эргүүл, шөнийн эргүүл болон замын цагдаагийн байнгын пост ажиллуулж, улмаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчлан сэргийлэх ажлыг тасралтгүй зохион байгуулсаны үр дүнд тодорхой төрлийн гэмт хэргүүд буурч, хэргийн илрүүлэлт 1 хувиар өссөн.

Тухайлбал Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 13 нэгжээр буюу 12.9 хувиар, иргэдийн өмчийн хулгай 6 нэгжээр буюу 13.6 хувиар, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 8 нэгжээр буюу 57.1 хувиар, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 4 нэгжээр буюу 25 хувиар, бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 4 нэгжээр буюу 30.8 хувиар,

гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 3 нэгжээр 9.1 хувиар, гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг 2 нэгжээр буюу 2.4 хувиар тус тус буурсан байна.

Харин хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 3 дахин, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 3.1 дахин, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 12 нэгжээр буюу 12.5 хувиар, дээрэмдэх гэмт хэрэг 2 нэгжээр буюу 66.7 хувиар, залилах гэмт хэрэг 2 нэгжээр буюу 50 хувиар, хүүхэд оролцсон гэмт хэрэг 5 нэгжээр буюу 55.6 хувиар, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 8 нэгжээр буюу 12.7 хувиар тус тус өссөн байна.

Иймд өссөн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг дүн шинжилгээ, судалгааны баг судалж, тодорхой төрлийн урьдчилан сэргийлэх ажлыг энэ оны 4 дүгээр улиралд эрчимжүүлж ажиллах шаардлагатай байна.

### *Дөрөв. Санал*

1. Сахилга ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчдад “Ёс зүйн төлбөртэй сургалт”-ыг бүсчилсэн байдлаар зохион байгуулах.

2. Тус цагдаагийн газрын барилга нь 2002 онд ашиглалтанд орсноос хойш нэг ч удаа засвар хийгдээгүй ба барилгын урд жигүүрийн дээврийн хэсэг гадагш 5-10 см тэлж нуралт үүсэх эрсдэл бий болсон.

Иймд барилгад их засвар хийхэд шаардагдах мөнгөн хөрөнгийг Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад уламжилж шийдвэрлүүлэх.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ТАСГИЙН ДАРГА,  
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА Н.МИШИГДОРЖ

ХЯНАСАН: ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА,  
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА Б.МӨНХБАТ